

НҮҮҮҮҮҮ АЭИИАА ААӨҮ ОААААААЭЭЭИ ААЦДҮИ 2019 ОНЫ - ЭЭ АЭЭЭЭААААИҮ ОАЭЭАИ

2019 оны 12 дугаар
Нэгдүгээр сарын 16-ны өдөр
/нөхөрлөл/

Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар нь 2019 онд Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын Аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээ, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тулгуурлан харъяа хэлтэс, тасаг, хэсгүүдээс саналыг авч нэгтгэн Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг төлөвлөгөөг Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Аймгийн Засаг дарга болон Цагдаагийн ерөнхий газрын даргатай Цагдаагийн газрын даргын 2018 онд байгуулсан менежерийн үр дүнгийн гэрээг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоол, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам"-ын дагуу дүгнүүлж, Аймгаас баримтлан ажиллаж буй бодлого зорилтуудыг хариуцсан салбартаа амжилттай хэрэгжүүлсэн тус Цагдаагийн газрыг 2018 оны "Тэргүүний байгууллага"-аар, Цагдаагийн газрын даргыг "Тэргүүний байгууллагын удирдагч"-аар шалгаруулан Аймгийн Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, урамшуулсан.

Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж Цагдаагийн газрын 2018 оны үйл ажиллагааны тайланг Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэний зөвлөлд хүргүүлж, иргэд, олон нийтэд тайлагнах ажлыг сумдын Засаг даргын тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдтэй хамтран зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг сонсож, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар судалгаа авч ажиллалаа.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны 2019 оны сургалт, зөвлөгөөн энэ оны 01 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 3 удирдах алба хаагч хамрагдав.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтын дагуу Цагдаагийн газраас 2019 онд хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтыг гаргаж, харъяа хэлтэс, тасаг, хэсгийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж

2019 оны эхний хагас жилд 82, жилийн эцэст 114 баримт бичгийн биелэлтийг тооцож холбогдох алба, хэлтэст хүргүүлээ.

Тайлангийн хугацаанд Аймгийн Засаг дарга болон Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудаас ирүүлсэн цаг үеийн шинжтэй өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнан ажиллалаа.

Цагдаагийн газарт 2019 онд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудаас үйл ажиллагааны чиглэлээр 308 ажлын чиглэл, зөвлөмж ирүүлсэнийг хүлээн авч, нийт алба хаагч нарт танилцуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган үр дүнг тооцон ажилласан. Цагдаагийн газрын даргаас 2019 онд алба хаагчдад нийт 67 үүрэг, ажлын чиглэлийг хүргүүлж биелэлтийг тооцсон байна.

Тус Цагдаагийн газрын хэмжээнд 2019 онд аймгийн төвд 3475, Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст 3247, Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст 2617, нийт 9336 албан бичиг хүлээн авснаас хариутай 3956 албан бичгийн биелэлтийг цаг хугацаанд нь тооцон хариуг хүргүүлсэн, нийт 7432 албан бичгийг явуулсан бичгийн бүртгэлд бүртгэн ажиллажээ.

Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн 83 төрлийн хууль, дүрэм, журмын төслийг алба хаагч нарт танилцуулж, гаргасан саналыг нэгтгэн холбогдох алба, хэлтэст хугацаанд хүргүүлсэн.

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар 2019 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлан, төлөвлөгөөний дагуу зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг 21 удаа хуралдуулж, удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр 29, хүний нөөцийн талаар 73, сахилга хариуцлагын талаар 26, шагнал, урамшлын талаар 18, үйл ажиллагааны үр дүнгийн талаар 4, бусад 3, нийт 153 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хуралдааны шийдвэрийг үндэслэн хэлтэс, тасаг, хэсгийн дарга нарт шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр 6 мэдэгдэл хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам"-ыг үндэслэн Цагдаагийн газар, хэлтсийн даргаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр А дугаартай 96, хүний нөөц, боловсон хүчний чиглэлээр Б дугаартай 179 нийт 275 тушаалыг батлан гаргаж, бие бүрэлдэхүүнд танилцуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.

Цагдаагийн газрын түүхт 95 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргад зөвшөөрөл хүссэн албан бичгийг хүргүүлж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Ой тэмдэглэн өнгөрүүлэх /код 125/" журамд заасны дагуу байгууллагын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх зөвшөөрлийг ажлын чиглэлийн хамт ирүүлсэнийг хүлээн авч, хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө гарган ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд иргэний зөвлөл болон олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулах талаар 2018 он, 2019 оны 01 дүгээр сард тус тус санал хүргүүлж, Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор Цагдаагийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус иргэний зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 7 олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоо болон холбогдох зардлын төсвийг батлуулан сонгон шалгаруулалт явуулж, 7 иргэнийг сургалтанд хамруулан томилуулсанч, 3 иргэн хүсэлтээрээ чөлөөлөгдөж 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар тус Цагдаагийн газарт 4 олон нийтийн цагдаа ажиллаж байна.

Хүний нөөцийн чиглэлээр: Тус Цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/135, 2018 оны А/197, А/212 дугаар тушаалаар Удирдлага, Захиргааны удирдлагын тасаг, Эрүүгийн цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасаг, Хэрэг бүртгэх тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасаг, Шуурхай удирдлагын тасаг, Ерөө сум дахь цагдаагийн хэсэг, Алтанбулаг сум дахь цагдаагийн хэсэг, Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс /хэлтэс дотроо Удирдлага, Захиргааны удирдлагын хэсэг, Эрүүгийн цагдаагийн хэсэг, Мөрдөн байцаах хэсэг, Нийтийн хэв журам хамгаалах хэсэг, Баянгол сум дахь цагдаагийн хэсэг/, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс /хэлтэс дотроо Удирдлага, Эрүүгийн цагдаагийн хэсэг, Нийтийн хэв журам хамгаалах хэсэг/ гэсэн зохион байгуулалттайгаар батлагдсан.

Батлагдсан орон тоогоор тус Цагдаагийн газар нь офицер 137, ахлагч 142, энгийн 8 нийт 287 орон тоотой ажиллахаас 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар аймгийн төвд офицер 68, ахлагч 61, энгийн 4, бүгд 133, Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст офицер 39, ахлагч 45, энгийн 2, бүгд 89, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст офицер 26, ахлагч 26, энгийн 2, бүгд 51, нийт 270 алба хаагч ажиллаж байна.

2019 онд шинээр 55 алба хаагч, 1 ажилтныг томилж, 12 алба хаагчийг офицерын бүрэлдэхүүнд оруулж, 3 алба хаагчийг ахлахын албан тушаалд дэвшүүлж, 30 алба хаагчийг хүсэлтийнх нь дагуу ажлын байрыг өөрчлөн томилуулсан, 11 алба хаагчийг өөрсдийнх нь хүсэлтээр шилжүүлж, 7 алба хаагчийг чөлөөлүүлж, 5 алба хаагчид хүүхэд асрах чөлөө олгуулж, 5 алба хаагчийн хүүхэд асрах чөлөөг цуцлуулж, 3 алба хаагч албанаас халагдсан.

Тайлангийн хугацаанд тус Цагдаагийн газарт шинээр ажилд орох хүсэлт гаргасан 58 иргэнийг судлан, материалыг хүргүүлж, сонгон шалгаруулалтад 25 иргэн тэнцэж, ахлагчийн сургуулийг төгсөн томилогдон ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Цэргийн хүндэт тэмдэг” медалиар 1 алба хаагч, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Цагдаагийн алдар” хүндэт тэмдэгээр 1 алба хаагч, Цагдаагийн ерөнхий газрын шагнал “Цагдаагийн гавъяа” тэмдэгээр 9 алба хаагч, “Хүндэт жуух”-аар 20 алба хаагч, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар хугацааны цагдаагийн дэд хурандаа цолоор 2 алба хаагч, цагдаагийн ахмад цолоор 4 алба хаагч, цагдаагийн ахлах дэслэгч цолоор 10 алба хаагчийг, “Цагдаагийн гавъяа” тэмдгээр 2, Монгол цагдаа медалиар 1 ахмад ажилтан тус тус шагнагдсан.

Хүний нөөцийн мэргэжилтнээс 110 алба хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийж, шинээр 37 хувийн алба хаагчид хувийн хэрэг нээж, томилолтын карт хөтөлж ажиллав.

Хүний нөөцийн цахим санд шинээр 48 алба хаагчийг бүртгэж, ажлын байр өөрчлөгдсөн, халагдсан, чөлөөлөгдсөн, шилжсэн 41 алба хаагчийн хөдөлгөөнийг хийж, 282 алба хаагчийн мэдээлэлд баяжилт хийсэн.

Шинээр 55, албан тушаал өөрчилсөн 8 алба хаагчид үнэмлэх, энгэрийн тэмдэг олгуулж, албанаас чөлөөлөгдсөн, халагдсан 10 алба хаагчийн албаны үнэмлэх, энгэрийн тэмдэгийг хураан авч, Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн байна.

Цагдаагийн газарт тогтвор суурьшилтай идэвхи зүтгэл гарган ажиллаж байгаа 15 алба хаагчийг Цагдаагийн ерөнхий газрын шагналаар шагнуулах, Албаны төлөө 1, 2, 3 дугаар зэргийн медалиар шагнуулах болзол шалгуур хангасан 64 алба хаагчийн, Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт заасан “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний

мөнгөн урамшлыг 5 жил тутам олгох” заалтын дагуу 34 алба хаагчийн материалыг тус тус бүрдүүлж Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст уламжлан мөнгөн урамшууллыг олгуулсан.

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийг шинээр төгсөж тус Цагдаагийн газарт томилогдсон 8 алба хаагчдын хүлээн авч, итгэлцлийн гэрээ байгуулж, сурган дадлагажуулах төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлт үр дүнг тооцсон.

Цагдаа, дотоодын цэргийн төрийн тусгай албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж, ахлагчийн сургууль төгсөн, нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс байгууллагын сул орон тоог нөхөх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж 2019 онд 47 алба хаагчийг томилуулж, цагдаагийн тангараг өргүүлэн, алба хаах болон итгэлцлийн гэрээ байгуулж, сурган дадлагажуулах төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний дагуу Цагдаагийн газрын 2019 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг 5 чиглэлийн хүрээнд 40 ажил, арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн, хэрэгжилтийг ханган 2019 оны жилийн эцсийн биелэлтийг 4.5 буюу 94.7 хувьтай тооцож, Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэст хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд тус Цагдаагийн газраас “Зорилтыг зорилго болгоё” илтгэлийн уралдаан, “Сар шинийн баяр”-ыг тохиолдуулан ахмад ажилтнуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, шинээр томилогдсон алба хаагчдыг тангараг өргүүлэх ёслолын ажиллагаа, “Ээждээ захидал бичих уралдаан”, “Дээлтэй Монгол” арга хэмжээ, “Би цэвэр бичигтэн” хичээнгүй бичих уралдаан, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Цэцэгт мэндчилгээ”, “Ээждээ хүргэх захидал”, эмэгтэй алба хаагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, “Ахмадуудаасаа суралцай” уулзалт, “Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх зөвлөгөөн, “Ногоон тууз” аян, “Талархалын өдөр” арга хэмжээ, “Урлагийн бага наадам”, “Гэргийдээ илгээх чин сэтгэлийн захидал”-ын уралдаан, “Хүүхэд бидний гэрэлт ирээдүй” өдөрлөг, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, сахилгын дүрмийг хэн сайн судалсан бэ?” асуулт хариултын тэмцээн, цагдаагийн албаны үйл ажиллагааг алба хаагчдын гэр бүлийн гишүүдэд сурталчлан таниулах, тэдний ажил, үүргийн онцлог, хийж бүтээсэн ажлын ололт, амжилтыг өгүүлсэн ил захидлыг хүргүүлэх үйл ажиллагаа, “Цагдаагийн болон дотоодын цэргийн алба хаагчдын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх хүндэтгэлийн арга хэмжээ, “Бид мартахгүй” өдөрлөг, сар бүр төрсөн өдөр нь тохиож буй алба хаагч нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Шилдэг мөрдөгч” тэмцээний эхний үе шат болгож “Хэргийн газрын үзлэгийг хэн сайн хийх вэ” тэмцээн, “Сүлд” чуулгын үлээвэр найрал хөгжмийн аялгуу, амжилт хүссэн мэндчилгээ, “Эрүүл өглөөний цай”-тай “Стрессгүй өдөр” уриатайгаар өнгөрүүлэх арга хэмжээ, “Яг түүн шиг” уралдаан тэмцээн, “Бидны бахархал” сэдэвт цагдаагийн тухай дууны тэмцээн, “Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ” асуулт, хариултын тэмцээн, “Би Монгол хүн өдөрлөг” зэрэг соёл хүмүүжлийн арга хэмжээ, алба хаагчдын бие бялдар, биеийн тамир спортыг хөгжүүлэх чиглэлээр “Шатар, даам, дартс”, “Сагсан бөмбөг”, буудлагын аварга шалгаруулах тэмцээн, холимог багийн нөхөрсөг гар бөмбөгийн тэмцээн, “Хөгжөөнт буухиа”, “Хөл бөмбөг”, “Цасан урлал”, явган аялал, хүчний 3 төрөлтийн хүндийн өргөлтийн тэмцээн, “Аав, ээж, би” хөгжөөнт буухиа тэмцээн зэрэг 15 төрлийн уралдаан, тэмцээнийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний

дагуу нийт 115 ажил, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 21461 алба хаагч хамрагдсан нь нийт бие бүрэлдэхүүний 84.8 хувийг эзэлж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба, газар, хэлтсээс зохион байгуулсан 4 төрлийн тэмцээнд 15 алба хаагчийг оролцуулсан.

Цагдаагийн газрын алба хаагчдаас санаачлан улирал бүр 1 сайн үйлсийн аян өрнүүлж, зохион байгуулахаар төлөвлөн хамт олны санаачилгаар 2019 оны 1 дүгээр улиралд Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт 900.000 төгрөгний өртөг бүхий хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппаратыг худалдан авч, хүлээлгэн өгсөн.

2 дугаар улиралд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр сайн үйлсийн аян зохион байгуулахаар төлөвлөж 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдөр энэ ажлын эхлэл болгон “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлээр” Улаанбаатар хотын Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүний хөгжлийн ерөнхий газрын багш, хэлмэрч, орчуулагч С.Бямбадэлгэр, ОУ-ын хүний эрхийн сургагч багш, иргэдийн соёлын төвийн тэргүүн, “Дархан найрамдал” ТББ-ын гүйцэтгэх захирал З.Дуламсүрэн, Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч Ц.Батсүх, Аймгийн халамж үйлчилгээний газрын сангийн олголт хариуцсан мэргэжилтэн Э.Энхгэрэл нартай хамтран Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн, хөгжлийн бэрхшээлтэй 37 иргэнийг хамруулсан хууль эрх зүйн сургалтыг зохион байгуулсан.

3 улиралд тус Цагдаагийн газрын 2019 оны 08 дугаар сард сайн үйлсийн аян зохион байгуулж 1 алба хаагчийн эмчилгээний зардалд нийт алба хаагчдаас 2.300.000 мянган төгрөг, мөн Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран сайн үйлсийн аяныг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэний 2 хүүхдэд иж бүрэн хичээлийн хэрэгсэл, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс үүсэн байгуулагдсаны түүхт 35 жилийн ойн арга хэмжээний хүрээнд алба хаагчдаас гаргасан санал, санаачилгаар Сайхан сум дахь Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн 1 өрөө, тасалгааг нийт 500.000 төгрөгийн өртөгт багтаан засвар, үйлчилгээ хийж тохижуулж, өрх толгойлсон 1 эмэгтэйд хүнс, хувцас, эд материалын дэмжлэгийг тус тус үзүүллээ.

Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар "Сургалтын баг"-ийг Захиргааны удирдлагын тасгийн даргаар ахлуулан 10 алба хаагчийг бүрэлдэхүүнтэй байгуулан "Цагдаагийн газрын 2019 оны сургалтын төлөвлөгөө"-г баталж, харъяа хэлтэс, тасаг, хэсэгт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Албаны сургалтыг алба хаагчдын мэдвэл зохих хууль тогтоомжийн чиглэлээр 35 удаагийн 46 цагийн 5716 алба хаагч, алба хаагчдыг хөгжүүлэх чиглэлээр 16 удаагийн 19 цагийн 1876 алба хаагч, дадлагажуулах чиглэлээр 7 удаагийн 12 цагийн 975 алба хаагч, бие бялдрын бэлтгэлжилтийг хангах чиглэлээр 10 удаагийн 18 цагийн 1527 алба хаагч, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 28 удаагийн 36 цагийн 4185 алба хаагч нийт 96 удаагийн 131 цагийн давхардсан тоогоор 14279 алба хаагчийг хамруулан ажлын байран дахь сургалтыг зохион байгуулж, Цагдаагийн байгууллагын сургалтын “e.Surgalt” программд шивж ажиллалаа.

Зарим төрлийн сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж байна. Тухайлбал: Нийслэлийн Цагдаагийн газар, Сүхбаатар сумын 1 дүгээр сургууль, Хилийн цэргийн 0243, 0101 дүгээр анги, Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Татварын хэлтэс, Алтанбулаг сумын ХАА-н тасаг, Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Нэгдсэн эмнэлэг, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Авлигаас урьдчилан сэргийлэх иргэний зөвлөл, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, Аймгийн Прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын “Сүүж уул” сэргээн засах, амралт сувиллын

газар, Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Улаанбаатар хотын Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүний хөгжлийн газар, "Дархан найрамдал" төрийн бус байгууллага, Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар зэрэг 28 байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Цагдаагийн газрын хэмжээнд 2019 онд гадаад сургалтанд 2 алба хаагчийг, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд 35 удаагийн мэргэшүүлэх болон давтан сургалтад нийт 63 алба хаагчийг, Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн магистрын сургалтад 2, бакалаврын сургалтад 12 алба хаагчийг хамруулсан байна.

Цагдаагийн газрын түүхт 95 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд алба хаагчдын ажиллах орчин нөхцөл, мэргэжлийн ур чадвар, албандаа хандах хандлагыг сайжруулах зорилгоор "Буман нарс" амралтыг газрыг сэргээн засварлаж, "Хээрийн сургалтын нэгдсэн төв"-ийг байгуулан 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдөр ашиглалтанд орууллаа.

Тус Цагдаагийн газраас Цагдаа, дотоодын цэргийн Сургалтын нэгдсэн төвтэй хамтран 2019 оны 09 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд ахлагч бүрэлдэхүүний "Мэдлэгээ сорьж, туршлагаа хуваалцая" сэдэвт 2 өдрийн сургалтыг Цагдаагийн газрын Хээрийн дадлага сургалтын төвд зохион байгуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн Сургалтын нэгдсэн төвийн 3 сургагч багш Цагдаагийн газрын галт зэвсэг эзэмших эрх бүхий алба хаагч нарт 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Хилийн цэргийн 0243 дугаар ангийн буудлагын талбайд галт зэвсэг эзэмших ур чадвар олгох практик буудлагын сургалтыг зохион байгуулж, 95 алба хаагчаас бичгийн болон бие бялдарын шалгалт авч ажилласан.

Эрсдлийн удирдлага, дотоод аудит, хяналт шалгалтын чиглэлээр: Цагдаагийн газрын төв байрны орчимд болзошгүй нөхцөл байдал үүссэн үед хамгаалалт хийх төлөвлөгөө, төв байрнаас нүүлгэн шилжүүлэх баримт бичиг, эд зүйлийн жагсаалт, Цагдаагийн газрын тасаг, хэсгийн алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангаж, өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах төлөвлөгөө болон албаны бэлэн байдлын схемийг шинэчлэн баталгаажуулсан.

Цагдаагийн газрын алба хаагч нарын үйл ажиллагаа, нийгмийн байдалтай танилцах, шалган зааварчлах ажлын 2019 оны хуваарь, төлөвлөгөөний дагуу тайлангийн хугацаанд Цагдаагийн газрын зөвлөлийн гишүүд 2 Цагдаагийн хэсэг, 8 сумын хэсгийн төлөөлөгч цагдаа нарын ажил, амьдралтай танилцаж, шалган зааварчлах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр ажил, сайжруулах чиглэлээр 8 зөвлөмж, зааварчилгыг хүргүүлж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Мөн нийт алба хаагч нарт цахим орчинг зөв зохистой ашиглах, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хувийн цахим хаягт албаны дүрэмт хувцастай зураг, албаны мэдээллийг тавихгүй байх талаар 2 удаагийн үүрэг, чиглэл хүргүүлсэн.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэхээр тусгагдсан ажил, арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөөг харьяа хэлтэс, тасаг, хэсгүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан 2019 оны эхний хагас жилийн биелэлтийг 4.0 буюу 90 хувьтай тооцон Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Тус Цагдаагийн газрын 126 алба хаагчийн 2018 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн, эрх бүхий албан тушаалтнаар 3 алба хаагчийг тушаалаар томилуулан ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөний үеэр удирдлагуудад тараасан авлигаас урьдчилан сэргийлэх зурагт хуудсыг байгууллагын мэдээллийн самбарын авлигаас сэргийлье хэсэгт

байршуулан, аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгууллаа.

Авлигын эсрэг хууль, үндэсний хөтөлбөрийг сурталчилах чиглэлээр “Авлигаас сэргийлье” самбарыг шинээр хийлгэж, энэ чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаарх мэдээлэл болон иргэдийн санал, мэдээллийг хүлээн авах хайрцгийг тус тус байршуулан ажиллаж байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт алба хаагч нарт Сэлэнгэ аймгийн Авлигаас урьдчилан сэргийлэх иргэний зөвлөлийн гишүүн Б.Буянтогтохтой хамтран 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 1 удаагийн 1 цагийн, 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр “Авлига ашиг сонирхлын тухай ойлголт” сэдвээр 1 удаагийн 1 цагийн сургалтыг, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Э.Мөнхтулга, Н.Оргил нар нийт алба хаагч нарт “Авлигын эсрэг хууль тогтоомж” сэдвээр сургалт хийж, нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих алба хаагчдын сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр алба хаагч нартаа санал, хүсэлтээ солилцов, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсээс Сайхан сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 2019 оны 03 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд “Авлигагүй-архигүй нийгэм” сэдэвт урлаг, спортын уралдаан тэмцээнийг төсвийн 19 байгууллагын хамруулын тус тус зохион байгуулж, авлигын эсрэг хууль тогтоомжийг сургалталчлах ажлыг зохион байгуулж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс ирүүлсэн чиглэлийн дагуу энэ оны 06 дугаар сарын 19-ний өдөр алба хаагчдын дунд “Авлига, ашиг сонирхлоос ангид байх”, “Алба хаагчийн ёс зүйг дээшлүүлэх нь” сэдэвт илтгэлийн уралдааныг зохион байгуулж, шалгарсан 1 илтгэлийг нийт алба хаагч нарт түгээж, амжилттай оролцсон алба хаагчийг шагнаж урамшуулсан.

Тус Цагдаагийн газраас авлигын эсрэг алба хаагчдыг соён гэгээрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээр алба хаагч, ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, авлигын хор аюулыг ухуулан сурталчлах зорилгоор “Авлигаас ангид бай”, “Би шударга алба хаагч”, Авлигын хор аюул” сэдэвт зөвлөмж 45, “Авлигыг мэдээлье” гарын авлага 50 ширхэгийг бэлтгэж нийт алба хаагчдад тарааж, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь хэсэгт заасны дагуу 110 тусгай дугаарын утасны сурталчилгааны шторкийг татан авч Цагдаагийн газрын цахим хаягт байршуулан иргэд, олон нийтэд түгээж ажилласан байна.

Авлигатай тэмцэх газарт зохион байгуулагдсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургагч багшийн сургалтанд 1 алба хаагчийг хамруулсан.

Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр: Алба хаагчийн сахилга, ёс зүйг сайжруулах, өргөсөн тангарагтаа үнэнч байж, бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэж, шударга, зарчимч, ёс зүйтэй, шуурхай мэргэшсэн үйл ажиллагааг хэвшүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/57 дугаартай тушаал болон мөн газрын дэд даргын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 3/73 дугаартай албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу энэ оны 02 дугаар сарын 28-ны өдөр тус Цагдаагийн газрын 198 алба хаагчтай “Итгэлцлийн гэрээ”-г байгуулж, биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд тус Цагдаагийн газрын алба хаагчдаас 43 алба хаагч сахилгын зөрчилд холбогдсоны 26 буюу 60.7 хувийг офицер, 17 буюу 39.2 хувийг ахлагч алба хаагч эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал сахилгын зөрчил 14-өөр буюу 26 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Үүнээс ажлын хариуцлага алдсан 18 буюу 41.0, ажил тасалсан 4 буюу 9.9, архидан согтуурсан 7 буюу 16.6, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн 4 буюу 9.9, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн 8 буюу 18.0, үүрэг даалгавар үл биелүүлсэн 3 буюу 6.2 хувийг тус тус эзэлж байна.

Сахилгын зөрчилд холбогдсон алба хаагчдын 15 буюу 34.6 хувьд нь сануулах, 21 буюу 48.8 хувьд нь албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20.0 хүртэл хувиар бууруулах, 2 буюу 4.4 хувьд нь цагдаагийн цол бууруулах, 5 буюу 11.9 хувьд нь цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэлийг оногдуулсан.

Нийт сахилгын шийтгэлийн 4 буюу 9.9 хувийг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар, 18 буюу 41,8 хувийг тухайн байгууллагын даргын тушаалаар, 21 буюу 48,8 хувийг харьяа цагдаагийн хэлтсийн даргын тушаалаар тус тус оногдуулсан ба 28 буюу 65.1 хувийг тухайн байгууллагын дотоодын хяналтаар, 10 буюу 23.2 хувийг иргэдийн гомдол мэдээллээр, 5 буюу 11.6 хувийг төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичиг, материалаар тус тус илрүүлсэн.

Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 29 өргөдөл, гомдол ирүүлж, 40 алба хаагчийг холбогдуулан шалгасны 29 буюу 72.5 хувийг офицер, 11 буюу 27.5 хувийг ахлагч алба хаагч эзэлж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар: Тайлангийн хугацаанд тус Цагдаагийн газрын удирдах албан тушаалтнуудад иргэд, байгууллагаас 299 өргөдөл ирүүлснийг урьд оны мөн үетэй харьцуулахад 69 нэгж буюу 18.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 34 буюу 9.2 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 6 буюу 1.6 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 19 буюу 5.7 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 141 буюу 38.5 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 58 буюу 15.9 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 110 буюу 29.9 хувь нь бусад өргөдөл гомдол байна. Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлыг 100 хувь шийдвэрлэж, хариуг өгч ажилласан.

Тус Цагдаагийн газраас сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг харьяа хэлтэс, тасаг, хэсэг сар бүр, нэгдсэн зөвлөгөөнийг улирал бүр зохион байгуулан Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлыг хэлтэст дүнг хүргүүлж хэвшсэн.

2019 онд нэгдсэн сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан уриалгыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцон ажиллалаа.

Цагдаагийн газрын 2019 оны 03 дугаар улирлын сахилга, хариуцлагын зөвлөгөөнөөс гаргасан "Дэргэдээсээ суралцаж, сахилга, хариуцлагаа дээшлүүлэе" уриалгын хүрээнд 9 заалт бүхий төлөвлөгөө, 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс сахилга ёс зүйг сайжруулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх 1 сарын аяныг зохион байгуулж, аяны хүрээнд Мандал, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст 2019 оны эхний 9 сарын сахилга хариуцлагын байдалд дүн шинжилгээ хийж сахилга хариуцлагын зөвлөгөөнийг зохион байгуулан гаргасан уриалгын дагуу ажил, арга хэмжээний төлөвлөгөөг тус тус гарган, үр дүнг тооцон ажиллаж байна.

2019 онд сахилга, ёс зүйг дээшлүүлэх, албандаа хандах хандлагыг өөрчлөх, алба хаагчдаас гаргасан зөрчил, дутагдлыг бууруулах чиглэлээр сахилга ёс зүйн зөвлөлөөс "Сахилгын зөрчил гаргасан алба хаагчид зөвлөгөө өгч, итгэл хүлээлгэх хуудас"-ыг гардуулсан, алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, гэр бүлийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, алба хаагч бүрийн албандаа хандах хандлагыг сайжруулах, хамт олны дунд эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдөр "Хариуцлагатай гэр бүл" сэдэвт өдөрлөг, арга хэмжээг зохион байгууллаа.

Сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргасан 13 алба хаагчийг ёс зүйн төлбөртэй сургалтанд хамруулж ажилласан.

Тус Цагдаагийн газарт 2019 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар аймгийн төвд 1, Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст 4, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст 2 нийт 7 прокурорын шаардлага ирүүлсэнийг хүлээн авч холбогдох шалгалтын ажиллагааг явуулж 1 алба хаагчид сануулах, 15 алба хаагчид албан тушаалын сарын үндсэн цалинг 10-20 хувиар 1-4 сар хүртэлх хугацаагаар бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан.

Урьд оны мөн үеэтэй харьцуулахад прокурорын шаардлага 10-аар буюу 58.8 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Прокурорын байгууллагаас ирүүлсэн шаардлага бүрийг цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэн, зөрчил дутагдлыг арилгуулах талаар ажил, арга хэмжээг зохион байгуулж, хариуг хүргүүлж хэвшсэн.

Прокурорын шаардлагад дурьдагдсан зөрчлийг арилгуулах эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээл, цаашид анхаарах асуудлыг шийдвэрлэх зорилгоор прокурорын байгууллагатай хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг 6 удаа, Аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн газрын хамтарсан зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, Аймгийн Прокурорын газартай хамтран эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагч нарт 6 удаагийн 12 цагийн сургалтыг зохион байгуулаад байна.

Хоёр.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар:

Тус Цагдаагийн газраас Цагдаагийн байгууллагын 2019 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөг боловсруулан харьяа Мандал, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Энэ онд Цагдаагийн газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 4 бүлэг 56 заалтын хүрээнд боловсруулан батлуулж ажилласан бөгөөд хэрэгжилт 91,6 хувьтай байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд 19 төрлийн санал бүхий албан бичгийг хүргүүлж, тус зөвлөлөөс 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 12 саналыг тусгуулан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн төлөвлөгөөний хүрээнд тус Цагдаагийн газраас зохион байгуулах урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, Мал хулгайлах болон Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2019 оны төлөвлөгөөнүүдийн хүрээнд аймгийн хэмжээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хууль зүйн яаманд 4, Зам тээврийн яаманд 2, Цагдаагийн ерөнхий газарт 6, Нутгийн захиргааны байгууллагад 59 нийт 71 танилцуулгад 94 саналыг тусган хүргүүлснээс 45 асуудлыг хэлэлцүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, сумын Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд тодорхой саналыг хүргүүлснээр 2 тогтоол, 7 захирамж, бусад 9 шийдвэрийг гаргууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээнд 9 чиглэлийн саналыг хүргүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Мандал сумын авто замыг гэрлэн дохио, стандартад нийцсэн камержуулалттай болгох зориулалтаар орон нутгийн төсвөөс

85 сая төгрөг, Шаамар сумын нутаг дэвсгэрт замын цагдаагийн хяналтын пост барих зориулалтаар улсын төсвөөс 79 сая төгрөг, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалан байрлуулах түр хамгаалах байр байгуулах зорилгоор Азийн хөгжлийн банкны төслөөр 152.5 сая төгрөг зэрэг 4 төрлийн 316.5 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгүүлэхээр тусгуулсан.

Тус Цагдаагийн газраас төсөвт 411.375.000 төгрөгний торгуулийн мөнгийг төвлөрүүлж, 127.832.000 төгрөгний санхүүжилт хийлгэхээр шийдвэрийг гаргуулж, 17.012.000 төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулаад байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дээд шатны байгууллагаас ирүүлсэн 1 тушаал, 62 төрлийн үүрэг, зааварчилгаа, ажлын чиглэл, зөвлөмжийг хүлээн авч, 52 төрлийн биелэлтийг тооцон ажилласан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулсан 27, орон нутгийн хэмжээнд 4 төрлийн нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулан үр дүнг нь тооцож ажиллахын зэрэгцээ улсын хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний үед болон тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус Цагдаагийн газраас нийт 47 төрлийн хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан байна. Тухайлбал: Улсын хэмжээнд зохион байгуулсан “Сар шинэ-2019”, “Хулгайлах гэмт хэргээс сэргийлье”, “Автомашин-2019”, “Нэг хором”, “Залилах гэмт хэрэг-Оргодол-Шийдвэрлэлт-2019”, “Хурд”, “Орон нутгийн зам”, “Нэг хором хүлээ”, “Бяцхан зорчигч”, “Мотоцикль”, “Ачааны машин-ачаа тээвэрлэлт”, “Нуугдмал”, “Хүүхэд хамгаалал” “Зөв тусгал”, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал”, “Бодис 2019”, “Байгалиа хамгаалъя”, “Ойлгоё, Хүндэлье”, “Ятгах тусам нягтал” зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, биелэлтийг нь тухай бүр хүргүүлсэн.

“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл”, “Тэсрэх бодис-2019”, “Устгал-2019”, “Малын хулгай - хяналт”, “Мансуурал - хяналт”, “Хөрш амгалан бол бид амгалан”, “Цахим тоглоом - хяналт”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо” нэгдсэн арга хэмжээнүүдийг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулан, үр дүнг тооцсон.

Орон нутгийн хэмжээнд “Гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тусгай дуут гэрэл дохио”, “Архидалттай тэмцэх ажлын төлөвлөгөө”, “Шашин”, “Цахим тоглоом 1,2” зэрэг тусгай арга хэмжээг зохион байгууллаа.

Сум, орон нутгийн хэмжээнд “Сэрэмжлүүлэг-1”, “Сэрэмжлүүлэг-2”, Хүдэр, Бугант, Ерөө, Зүүнбүрэн, Алтанбулаг, Сүхбаатар сумдын хэмжээнд “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Хаалга ба цонх” хэсэгчилсэн арга хэмжээг Сайхан, Орхон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул сумдын нутаг дэвсгэрт, “Камержуулалт”, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс сэргийлье”, Ерөө суманд “Нэг хором тэвчье”, Сайхан суманд “Нэг цохилт”, “Залилах гэмт хэргээс сэргийлэх нь”, “Цахим залилах гэмт хэргээс сэргийлье”, “Нийтийн тээвэр”, “Хамгаалах бүс”, “Сар шинэ-Аюулгүй тээвэр”, “Хүнд даацын авто машин-Оч баригч”, “Дугуйтай уралдаан”, “Тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа, дуу чимээ зөвшөөрөгдөх хэмжээнээс илэрхий хэтэрсэн тээврийн хэрэгсэлд хяналт тавих”, “Замын тэмдэг, тэмдэглэгээний бүрэн бүтэн байдал”, “Улсын дугаар”, Ерөө суманд “Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлье”, Мандал суманд “Хяналт”, Сүхбаатар суманд “Хүчирхийллээс сэргийлье”, “Хүүхэд-нэг хором”, Сайхан суманд “Хүүхэд, хүүхэддээ тусалъя” аян, Мандал суманд “Бид хүүхэд”, “Бүртгэл-2019”, Сүхбаатар сумын хэмжээнд “Сэргийлэх”, “Согтуу” хэсэгчилсэн арга хэмжээг, “Лонх” хэсэгчилсэн арга хэмжээг Мандал сумын Хэрх тосгонд, “Цахим тогтоом”, “Хандалт”, Бугант тосгонд “Техник бүртгэл-экскаватор”, Сүхбаатар, Мандал, Орхон, Цагааннуур сумдад “Мялзан”, “Зөрчил”, Алтанбулаг суманд “Мод”, “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Хууль бус ан”, “Гол ус” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулав.

Нийт зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн хүрээнд 148 удаа нэгдсэн үзлэг шалгалтыг зохион байгуулж, зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллав.

2019 онд тус Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, аж ахуйн нэгжид болон сумдын иргэдэд чиглэсэн 774 удаагийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж мэдээлэл хийсэн байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 38 удаагийн сургалт, мэдээллийг зохион байгуулж ажиллалаа. Тухайлбал: “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ий ажилчдад, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо”, Цагааннуур сум, Жавхлант, Хушаат сумын иргэд, Хот тохьжилт үйлчилгээний газрын ажилчид зэрэг газруудад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд “Зөв тусгал” хөдөлгөөний хүрээнд төрийн болон төрийн бус 158 байгууллагын 9178 иргэд, ерөнхий боловсролын 34 сургуулийн ахлах ангийн 6214 сурагчдад “Зөв тусгал”, “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо”, “Бид ирээдүйн эзэд” сэдэвт сургалтыг зохион байгуулж ажиллалаа.

Тухайлбал: Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Татварын хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хилийн цэргийн 0101, 0243 дугаар анги, Засаг даргын тамгын газар, Багийн засаг дарга нар, иргэдийн төлөөлөл зэрэг нийт 4256 иргэдэд Зөв тусгал”, “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо”, “Бид ирээдүйн эзэд” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

Аймгийн “Жаргалтай гэр бүл” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд хамтдаа” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар, “Хүйсийн тэгш эрх төв” төрийн бус байгууллагатай хамтран 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн байгууллагын оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Мөн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр “Жендер ба хүний эрх” сургалтанд 50 төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.

“Цахим тоглоом- хяналт” сэдэвт хэсэгчилсэн арга хэмжээг Цагааннуур суманд зохион байгуулж, тус суманд зохион байгуулагдсан “Эцэг, эхийн өдөрлөг”-ийн үеэр энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгууллаа.

Сайхан сумын Сайхан, Сант, Орхонтуул сумдын 96 иргэнд яриа таниулга хийв. Баруунбүрэн сумын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан “Малчдын зөвлөгөөн”-ий үеэр “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өмч хөрөнгөө хэрхэн хамгаалах вэ” сэдвээр 85 малчин иргэнд сургалт, ухуулга, яриа таниулгын ажлыг явуулав.

“Залилах гэмт хэргээс сэргийлэх нь” хэсэгчилсэн арга хэмжээг Сүхбаатар суманд зохион байгуулж, 20 байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан 110 удаагийн сургалтыг зохион байгуулж, иргэдэд мэдээ, мэдээлэл өгч, 2000 иргэн хамрагдсан.

Зам, тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан “Нийтийн тээвэр”, “Сар шинэ-Аюулгүй тээвэр” зэрэг нийт 6 нэгдсэн, 9 хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн хүрээнд 81 байгууллага, аж ахуйн нэгжид 64 удаагийн, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулагдсан ажил, арга хэмжээнүүдийн хүрээнд 51, Зөрчлийн тухай хууль болон Хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, бусад холбогдох сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулав.

Зохион байгуулсан сургалт мэдээлэл, уулзалт, өдөрлөгт нийт давхардсан тоогоор 998 байгууллага, аж ахуй нэгж оролцсон ба үүнээс төрийн байгууллага 466, төрийн бус байгууллага 39, аж ахуй нэгж 408, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж 6, ерөнхий боловсролын сургууль 34, цэцэрлэг 45 тус тус хамрагджээ.

Ухуулга яриа, сургалт сурталчилгаанд нийт 21499 иргэн хамрагдсан ба үүнээс Төрийн болон төрийн бус аж ахуй нэгжийн 6867 ажилтан, алба хаагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3439, малчин 1099, оюутан 1065, сурагч 6808, ажилгүй иргэн 2221 тус тус хамрагдсан байна.

Энэ хугацаанд алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 388 мэдэгдэл бичиж, 226 мэдэгдлийн хариуг авч, 152 мэдэгдлийн мөрөөр хийсэн ажлыг газар дээр нь шалгаж, зөвлөгөө өгсөн байна.

Тайлангийн хугацаанд зохион байгуулагдсан ажил, арга хэмжээний хүрээнд болон тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор МҮОНРТ, орон нутгийн “ММЭ”, “Эрдэнэ”, “Мандал” телевизүүдээр нийт 100 удаагийн, 261 минутын мэдээ, мэдээлэл бэлтгэн 177 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж, иргэдэд түгээлээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээнүүдийн хүрээнд “Сэлэнгэ цагдаагийн газар”, “Сэлэнгэ зар”, “Хөтөл цагдаа”, “Сум дундын Цагдаагийн хэлтэс” зэрэг олон нийтийн хандалт ихтэй бусад цахим хаягуудад нийт 391 мэдээ, мэдээлэл, санамж, сэрэмжлүүлэг байршуулж, иргэдэд түгээснийг 15658 иргэн хандаж, танилцсан байна.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан “Сар шинэ-2019”, “Хулгайлах гэмт хэргээс сэргийлье”, “Нэг хором”, “Яараад яахав дээ”, “Дураараа бишээ дүрмээрээ”, “Ойлгоё, Хүндэлье”, “Ятгах тусам нягтал”, “Хөрш амгалан бол бид амгалан” зэрэг аян, нэгдсэн болон аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээ, бусад ажил, арга хэмжээнүүдийн хүрээнд нийт 3 төрлийн гарын авлага, 35 төрлийн зурагт хуудас, 119 төрлийн санамж, сэрэмжлүүлэг, нийт 39358 ширхэг тараах материалыг бэлтгэн хэвлүүлж, иргэд олон нийтэд тарааж ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн татан оролцуулах ажлын зохион байгуулж, олон нийтийн эргүүлд МСҮТ, “Сэлэнгэ” тохьжилт үйлчилгээний газар, Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газар зэрэг 44 байгууллага, аж ахуйн нэгжийн 177 ажилтан, алба хаагч, 197 иргэнийг татан оролцуулж, тэдний туслалцаа дэмжлэгийг авч ажиллалаа.

Зохион байгуулсан ажил, арга хэмжээний үед давхардсан тоогоор 88 байгууллага, 54 аж ахуйн нэгж, малчдын 10 бүлэг, хөршийн хяналтын 10 бүлэг, “Өсвөрийн сэргийлэгч” 34 бүлгэм, 65 хамтарсан баг, сургуулийн 34 эргүүлийг мэргэжлийн удирдлагаар ханган зөвлөгөө өгч, хамтран ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 17 сум, 6 тосгон, 38 багийн хэмжээнд 38 хамтарсан баг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын 34 сургуульд “School Police” сургуулийн бүсийн эргүүл ажиллаж байгаа бөгөөд 2019 онд нийт 25704 эцэг эх сургуулийн бүсийн эргүүлд ажиллаж, Цагдаагийн газар, хэлтсээс сургуулийн бүсийн эргүүлийн үйл ажиллагааг давхардсан тоогоор 232 удаа шалгаж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллалаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 19 байгууллага, 16 аж ахуйн нэгж, 13 хөршийн хяналтын бүлэг, 38 хамтарсан баг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайн онд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан

сэргийлэх чиглэлээр 42 байгууллага, аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдлагаар хангаж ажиллав.

Аймгийн Сайхан, Орхон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул сумдын нийт 7 ерөнхий боловсролын сургуулийн “Өсвөрийн сэргийлэгч бүлэг”, хамтарсан баг болон сургуулийн орчимд эргүүлийн үйл ажиллагаа явуулж буй бүлгүүдэд хүүхэд хамгаалал, хүүхдийг гэмт халдлагаас хамгаалах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд хуулиар хүлээсэн иргэнийхээ үүргийг биелүүлэх, хүүхэд, залуучуудыг эх оронч, өв тэгш хүмүүжлээр хүмүүжүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор тус Цагдаагийн газраас хүүхэд хамгаалагч туршилтын төслийн хүрээнд ахмад ажилтан Б.Түвшинжаргал, Д.Наранцэцэг нарыг 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүүхэд хамгаалагчаар томилуулан аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран ажиллаж байна.

2.2. Эрүүгийн цагдаагийн тасгийн үйл ажиллагааны чиглэлээр: Тус тасгаас 2019 онд нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, баримтжуулах, чиглэлээр Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Тээврийн цагдаагийн алба, Хар тамхитай тэмцэх газар, Цагдаагийн газраас зохион байгуулсан “Сар шинэ”, “Устгал”, “Бүртгэл хяналт 2”, “Улсын дугаар”, “Эко 2019”, “Илрүүлэлт, оргодол, шийдвэрлэлт”, “Зэвсэг”, “Хар тамхи хяналт”, “Мал хяналт” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд тодорхой ажил арга хэмжээг хариуцсан орон нутагт зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллалаа.

Эрэн сурвалжлах “ASAP” санд 2019 онд нийт 330 хүн, мал амьтан, эд зүйлийн мэдээллийг бүртгэж, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж ажилласан. Энэ хугацаанд иргэд, байгууллагаас эрэн сурвалжлалт зарлуулахаар ирүүлсэн оршин суугаа газраасаа алга болсон 44 хүнд эрэн сурвалжлалт зарлаж, холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэн 41 хүний байгаа газрыг олж тогтоосон, шүүхээс даалгасан нийт 74 хүнийг эрэн сурвалжилснаас 57 хүнийг олж тогтоон, 17 хүнийг үлдэгдэлтэй, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 116-г эрэн сурвалжилснаас 104 хүнийг олж тогтоон 12 хүнийг үлдэгдэлтэй, оргодол этгээд 26-г эрэн сурвалжилснаас 21 хүнийг олж тогтоон 5 хүнийг үлдэгдэлтэй, тээврийн хэрэгсэл 12-ыг эрэн сурвалжилснаас 8 тээврийн хэрэгсэл олж тогтоон, 4 тээврийн хэрэгслийн үлдэгдэлтэй, 4 галт зэвсэг эрэн сурвалжилж 1-ийг олж тогтоон 3 үлдэгдэлтэй, мал, амьтан 18-ийг эрэн сурвалжилснаас 1-ийг олж 17 үлдэгдэлтэй, эд зүйл 44 эрэн сурвалжилснаас 20 эд зүйл олж тогтоон үлдэгдэл 24, аман зургаар 1 хүнийг эрэн сурвалжилж олж тогтоосон байна.

Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлсийг олж тогтоох чиглэлээр 2019 онд “Тулгалт”, “Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт”, “Сан” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж тухай бүр үр дүнг тооцож ажиллав.

Тус Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгаас 2, Мандал, Сайхан сумд дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасгаас тус бүр 1 алба хаагч Улаанбаатар хотод эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг олж тогтоох, нийслэл, орон нутаг дамжин хулгайлах, дээрэмдэх гэмт хэргүүдийг үйлдэж байгаа этгээдүүдийг баримтжуулах чиглэлээр зохион байгуулсан “Баримтжуулалт” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Эрүүгийн цагдаагийн албаны Эрэн сурвалжлах хэлтэстэй хамтран ажилласан.

Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: Эдийн засгийн мөрдөгч нар 2019 онд гэмт хэргийн шинжтэй нийт 102 гомдол хүлээн авч шалгасанаас 64 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 37 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 гомдол мэдээллийг бусад газарт шилжүүлсэн байна.

Хэрэг бүртгэлтийн давхардсан тоогоор нийт 74 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 29 хэргийг яллагдагчаар татах саналтай хэрэг бүртгэлтийн 14 хэргийг хаах саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн, одоо ажиллагаанд 29 хэрэг бүртгэлтийн хэргийн үлдэгдэлтэй шалгагдаж байна.

Тайлангийн хугацаанд хил залгаа аймаг, сумдын нутагт үйлдэгдэж буй эдийн засгийн болон хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийг шалгаж баримтжуулах зорилгоор 36 удаа, 128 хоног албан томилолтоор ажиллаж тухай бүр газар, хэлтэс, тасгийн даргад хийж гүйцэтгэсэн ажлаа танилцуулж, үр дүнг тооцуулсан.

Улсын хэмжээнд зохион явагдсан “Судалгаа”, “Нуугдмал”, “Мөнгө-угаалт хяналт”, “Нийгэмлэг”, Тусгай сан”, “Тэсрэх бодис 2019”, “Эко-2019” нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт үр дүнтэй зохион байгуулж, нэгдсэн танилцуулга, хийж гүйцэтгэсэн ажлын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Тагнуулын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран 4 удаа хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж 3 гэмт хэрэг илрүүлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж, зөрчлийн шинжтэй 4 үйлдлийг харъяаллын дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлж шийдвэрлүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/270 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах хугацаанд бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 22 нөхөрлөлийн нийт 186 иргэн, 63 экскеватор, 23 ковш, 35 ачааны автомашин, 27 ширхэг алт угаах төхөөрөмж, 63 ширхэг монгол гэр, 9 контейнер, 7 бульдозор зэргийг ашигт малтмал олборлож байсан талбайгаас албадан буулгасан.

Хулгайлах болон мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: Аймгийн хэмжээнд 2019 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлд заасан мал хулгайлах гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 71 бүртгэгдэн шалгагдсанаас 56 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 14 гомдол мэдээлэлийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 гомдол мэдээллийг харъяаллын дагуу холбогдох газарт шилжүүлж ажилласан.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлээр 2019 онд тус Аймгийн Ерөө, Жавхлант, Зүүнбүрэн, Шаамар, Хушаат сумдын нутаг дэвсгэрээр нийт 6 удаа эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулж, Шаамар сумын 1 дүгээр багийн 1 иргэний 15 тооны адуу, Жавхлант сумын 1 дүгээр багийн 1 иргэний 19 тооны үхэр тус тус хулгайд алдагдсан хэргийг илрүүлж, Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газартай хамтран шалгалтын ажиллагааг явуулж байна.

Улсын хэмжээнд зохион явагдсан “Сар-Шинэ 2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр “Уулзвар” хэсэгчилсэн арга хэмжээг 2019 оны 01 дүгээр сарын 07-25-ны өдрүүдэд зохион байгуулж Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Хушаат, Ерөө Жавхлант, Мандал, Сайхан сум, Дулаанхаан, Түнхэл, Номгон тосгон, Дархан-Уул аймагтай хил залгаа мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг, газруудаар мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох мэдээ, мэдээлэл цуглуулах, шалгалтын ажиллагааг зохион байгуулж, мал бүхий иргэдэд “Малыг байнгын хариулга, хараа хяналтандаа байлгаж, малын хулгайчаас сэрэмжлэе” гэсэн 320 ширхэг санамж тараан, малын хулгайлах гэмт хэрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг Цагдаагийн газар, хэлтсийн жижүүрийн шуурхай албаны тусгай дугаарууд болон чиглэл хариуцсан эрүүгийн мөрдөгч нарт мэдэгдэж ажиллах талаар яриа таниулга хийж ажилласан.

Тус Цагдаагийн газраас 2019 онд мал хулгайлах гэмт хэрэг ихээр үйлдэгддэг, үйлдэгдэж болзошгүй Сэлэнгэ аймгийн Хушаат суманд 2019 оны 01

дүгээр сарын 11-ний өдөр, Жавхлант суманд 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр суманд тус тус сумдын Засаг даргын тамгын газартай хамтарч мал бүхий иргэдтэй уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, тэдний санал хүсэлтийг сонсож ажиллалаа.

Мөн 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд “Мал хяналт” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр харицсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг мал, мах зарж борлуулдаг цэг, зах, худалдааны төв, дэлгүүр болон, нядалгааны цэг, махны ченжүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө, Жавхлант, Хушаат, Зүүнбүрэн, Цагааннуур сум болон Дархан-Уул аймагт 2019 оны 09 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд 1 эрүүгийн мөрдөгч, 2 хэсгийн төлөөлөгч томилолтоор ажиллаж мал хулгайлах, хууль бус ан агнах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр эргүүл хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, сэжиг бүхий явсан 199 тээврийн хэрэгслийг шалгаж, 38 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тарааж, 50 айл өрхөөр зочилж 341 иргэнд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа, таниулга хийж ажилласан.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан бүрдэл хангаагүй, хүчин төгөлдөр бус гарал үүсэл бичсэн болон гарал үүслийн гэрчилгээгүй мал, мах тээвэрлэж явсан 32 иргэний гаргасан зөрчлийг материалжуулан зөрчлийн тухай хуулийн 13.5.1.1-д зааснаар арга хэмжээ тооцсон.

*Шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:*Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд сүүлийн 3 жилд Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26 дугаар зүйлд заасан “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” бүртгэгдээгүй, Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3.1 дэх хэсэг “Залилах” гэмт хэргийг үйлдэхдээ бусдын фэйсбүүк цахим хаягыг ашигласан 3 гэмт хэрэг бүргэгдсэн бөгөөд хэрэг бүртгэлтийн 193200021, 193200024, 193100148 дугаартай хэргүүдэд хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулж сэжигтэй этгээдүүдэд хяналт тавьж ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сумын хэмжээнд 14 цахим тоглоомын газар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус Цагдаагийн газраас зохион байгуулсан “Цахим тоглоом 1” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд уг газруудын үйл ажиллагааг 3 удаа шалгаж Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахад цахим тоглоомын газрууд гадна хэсэгтээ хаяг байршуулаагүй, ажиллах цагийн хуваарь, үнийн тариф, архи согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх, тамхи татахыг хориглосон тэмдэглэгээнүүдийг байхгүй, орчны гадна болон дотор хэсэгт хяналтын камерыг байшуулсан боловч санах багтаамж бага, үйлчлүүлж байгаа иргэдийг бүртгэх бүртгэлийн дэвтэртэй боловч тогтмол бүртгэдэггүй зэрэг нийтлэг зөрчил илэрснийг аж ахуй нэгжийн эрхлэгч нарт мэдэгдэж, зөвлөмж хүргүүлж, цахим тоглоомын төвүүдэд 2 төрлийн 36 ширхэг санамж, сэрэмжлүүлгийг тарааж, байршуулав.

Дээрх төвүүдийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, жижүүр багш болон өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн сурагчид хичээлийн цагаар тус төвөөр сурагчид үйлчлүүлж байгаа эсэхэд хяналт тавьж хамтран ажиллаж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр: 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Хар

тамхитай тэмцэх газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн алба хаагчид Аймгийн хууль хяналтын байгууллагын алба хаагч нартай хамтран Алтанбулаг авто замын шалган нэвтрүүлэх боомтод Хар тамхи, Мансууралтай тэмцэх олон улсын өдрийн арга хэмжээний хүрээнд өдөрлөг зохион байгуулж иргэдэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт мэдээлэл хийж, санамж, сэрэмжлүүлэн, богино хэмжээний шторк нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд түгээсэн.

Сүүлийн 3 жилийн байдлаар тус аймагт мансууруулах бодис сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар олж авсан ашигласан гэмт хэрэг 2017 онд 7, 2018 онд 2, 2019 онд 1 бүртгэгдэн шалгагдсан байна.

2019 онд хариуцсан нутаг дэвсгэрт мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй ургамал болох зэрлэг олс ургамлын тархац Алтанбулаг, Шаамар, Дулаанхаан, Хүдэр, Ерөө, Бугант, Жавхлант, Зүүнбүрэн, Хушаат, Мандал, Баянгол, Сайхан, Орхон, Сант, Орхонтуул зэрэг сумдуудын нутаг дэвсгэрт 500 орчим га талбайг хамран ургасан нь судалгаагаар тогтоогдож, “Устгал” нэгдсэн арга хэмжээг зохион явуулахад шаардагдах зардлын төсвийг тооцоо, судалгааг гарган 20 сая төгрөгийн төсвийг 2019 онд Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, зэрлэг олсны ургамлын хор хөнөөлийн талаар алба хаагчдад тайлбарлан таниулах, мэдээ, мэдээлэл авах, тархац байршил нь тогтоогдсон сумдуудын нутаг дэвсгэрт “Устгал” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан.

“Устгал” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газраас 31 алба хаагч, Байгаль орчин аялал жуулчлалын газраас 1 алба хаагч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 0413 дугаар ангиас 3 алба хаагч, орон нутгийн 23 иргэн нийт 58 хүн, хор цацагч трактор 11, албаны тээврийн хэрэгсэл 5, хувийн тээврийн хэрэгсэл 8 зэрэг техник хэрэгсэлтэйгээр тус аймгийн Баянгол, Мандал, Сайхан, Номгон, Баруунбүрэн, Орхонтуул, Сант, Орхон, Шаамар, Дулаанхаан, Зүүнбүрэн, Хүдэр, Жавхлант, Ерөө, Бугант, Хушаат, Алтанбулаг сумдуудын нутаг дэвсгэрт байрлах тариалангийн талбайн зах, гуу жалгаар ургасан зэрлэг олсны ургамлыг явганаар болон техник хэрэгсэл ашиглан зориулалтын хор /Раундап/ цацах, гараар зулгаах, шатаах, газрыг хагалж хөрсөөр нь эргүүлэх гэх мэт аргаар нийт 513 орчим га талбайг хамруулан устгалыг ажиллагааг явуулсан байна.

Эрүүл мэндийн байгууллагатай хамтран өвчний улмаас мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хэрэглэдэг 1964 этгээдэд хэсгийн байцаагч, төлөөлөгч нартай хамтран хяналт тавьж ажиллаж байна.

Хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээнээс гарах үр дагавар, хор уршигыг таниулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуулиуд болон Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 9-12 дугаар ангийн 2600 орчим сурагчдад сургалт, мэдээллийг зохион байгуулж, 2 төрлийн 1800 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тараасан.

Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газар болон тус цагдаагийн газраас энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 3 төрлийн мэдээллийг орон нутгийн хандалт ихтэй 35 группын 6082 гишүүдэд түгээж, олон нийтэд сурталчлах ажил зохион байгуулсан. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль, тогтоомж мөн хэрэгжүүлж буй хөтөлбөрийг аймаг орон нутагт сурталчлах талаар сумдын хэсгийн төлөөлөгч нарт зааварчилга хүргүүлж “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал” сэдвээр хичээл, сургалт бэлтгэн сум орон нутгийн иргэдэд энэ төрлийн гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах зааварчилга хүргүүлж, биелэлтийг тооцлоо.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд тухайн сум орон нутагт энэ төрлийн гэмт хэрэгт өртөж болзошгүй иргэдийн судалгаа гаргаж, ялангуяа бага насны хүүхэд, тэр дундаа ар гэр асран хамгаалагчтайгаа харилцаа муутай байдаг мөн гэрээсээ олон хоногоор дайждаг охид эмэгтэйчүүдийн судалгаанд тулгуурлан тэдгээр иргэдэд хандсан нийгмийн халамжийн үйлчилгээг ойртуулах, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг Олон нийтийн цахим хэрэгсэл болон, байгууллага аж ахуй нэгжүүдийн зарлалын самбарт байршуулан ажилласан.

Алтанбулаг суманд орших хилийн боомтын зарлал, мэдээллийн самбарт “Хүн худалдаалах гэмт хэрэг”-ээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл агуулсан зурагт хуудас байршуулж, Сүхбаатар, Мандал суманд байрлах төмөр замын өртөөний дэлгэцээр “Хүн худалдаалах гэмт хэрэг”-ээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ, мэдээллийг зорчигч, үйлчлүүлэгчдэд мэдээлэл түгээлээ.

“Улаанбаатар-Сэлэнгэ” чиглэлд зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлдэг “Зэлтэрийн Зам” ХХК-ний 4 тээврийн хэрэгсэл дотор “Хүний худалдаалах гэмт хэргийн талаар” ойлголт өгөх зорилгоор зурагт хуудас бүхий сэрэмжлүүлгийг байршуулсан.

Цагдаагийн Ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанаас улсын хэмжээнд зохион явуулсан “Нуугдмал” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан нарыг оролцуулсан зөвөлгөөнийг зохион байгуулж, Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага болон, орон нутгийн эмнэлгийн байгууллагын хамт олонтоо хамтран ажиллах талаар санал хүргүүлэн, энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй иргэдийн талаар мэдээ мэдээлэл өгч ажиллах талаар нэгдсэн ойлголттой болон ажиллаж байна.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд 2019 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэг 3 бүртгэгдэн шалгагдсан.

Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах асуудлаар Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын “Мөнгө угаах” гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн чиглэл хариуцсан алба хаагчдаас тухай бүр ажлын чиглэл авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна.

Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас зохион байгуулсан “Мөнгө угаалт-хяналт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрт брокер, диллер, андеррайтер, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Гүүд Сек” ХХК-ний үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхэд зөрчил дутагдал илрээгүй.

Эрүүгийн цагдаагийн тасгаас аймгийн Прокурорын газартай хамтран Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах тасаг, Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчдад Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах асуудал болон Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/96 дугаар тушаалаар баталсан “Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”, мөн прокурорын 2018 оны “Зааварт нэмэлт оруулах тухай” А/76 дугаар тушаалуудаар 1 удаагийн 2 цагийн сургалтанд, 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан “Мөнгө угаах” гэмт хэргийн ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх, хор уршигийн талаарх сургалтанд эрүүгийн мөрдөгч, мөрдөгч нарыг тус тус хамруулсан.

Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Арилжааны банк, Банк бус санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх газрын нийт 110

ажилтан, төрийн болон төрийн бус байгууллагын 180 алба хаагчдыг хамруулан нийт 14 аж ахуйн нэгж байгууллагын 290 алба хаагчдад “Мөнгө угаах болон Терроризмыг санхүүжүүлэх” гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал сэдвээр сургалт зөвлөгөөнийг аймгийн Прокурорын газартай хамтран зохион байгууллаа.

“Мөнгө угаах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээнд 5 төрлийн санамж, сэрэмжлүүлгийг байршуулан орон нутгийн хамгийн олон дагагчтай 14 бүлгэмийн 27403 хүнд түгээж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны зурагт хуудас 300 ширхэгийг сумдын хэсгийн төлөөлөгч нарт хувиалан өгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тарааж байршуулсан.

Цагдаагийн газарт бүртгэгдэн шалгагдсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 /Өмчлөх эрхийн эсрэг/, 18 /Эдийн засгийн гэмт хэрэг/, 24 /Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг/ дүгээр зүйлүүдэд заагдсан хэргүүдийг мөнгө угаах гэмт хэрэгтэй холбон шалгаж, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд мөрийн баримт, мөнгө санхүүтэй холбогдсон этгээдүүдийн талаар мэдээ мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж ажиллаж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр: Тайлангийн хугацаанд “Гэр хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Сэлэнгэ аймийн олон улсын худалдааны төвийн такси үйлчилгээ эрхэлдэг 13 жолооч нарт, энэ оны 03 дугаар сарын 23-ны өдөр аймгийн хэмжээнд худалдаа үйлчилгээ эрхэлдэг 22 аж ахуйн нэгж байгууллагын 37 иргэнд гэрч хохирогчийг хамгаалах чиглэлээр яриа таниулга хийж, Цагдаагийн ерөнхий газрын Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсээс ирүүлсэн шторкыг үзүүлэн 100 ширхэг санамж сэрэмжлүүлэг тараасан.

Мөн насанд хүрээгүй гэрч хохирогчийг хамгаалах чиглэлээр сумын хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хамтран ажиллаж гэмт хэрэгт өртөж хохирсон болон гэмт хэрэгт холбогдсон 134 хүүхдийн судалгааг хүргүүлж эрхийг нь хамгаалах чиглэлээр ажиллаж байна.

Төрийн болон төрийн бус 157 аж ахуйн нэгж байгууллагад 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 157 алба хаагч 950 иргэнд гэрч хохирогчийг хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулж, гарын авлага, боршуур зэргийг тарааж ажилласан.

Тус тасгаас 2019 онд алба хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор Өвөр Монголын Өөртөө засах оронд 1 алба хаагчийг хар тамхитай тэмцэх чиглэлээр, шинээр томилогдсон 7 алба хаагчийг “Эрүү, хэсгийн мөрдөгч нарын гүйцэтгэх ажлын эрх олгох” сургалтанд, 1 алба хаагчийг “Гэрч, хохирогчийн хамгаалах”, 1 алба хаагчийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх”, 2 алба хаагчийг “Террор үйлдэх гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа”, 1 алба хаагчийг “Соёлын өвийн хууль бус эргэлттэй тэмцэх нь”, 1 алба хаагчийг “Залилах, хөрөнгө завших гэмт хэргийг илрүүлэх арга тактик”, 2 алба хаагчийг “Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэгт хийгдэх ажиллагаа”, 1 алба хаагчийг “Мансууруулах бодис мөрдөн шалгах ажиллагаа” сэдэвт сургалтанд тус тус хамрууллаа.

2.3. Мөрдөн байцаах тасгийн чиглэлээр: Тус Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасаг нь 2019 онд $\text{äyìð õýðäëéí øëíæðýé}$ 301 äíìäóë , мэдээллийг ð¿ëýýí ääç , 225 буюу 74.7 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, эд $\text{ð¿¿äëéí õýðýä ¿¿ñäýæ}$, яллагдагчаар татсан 20 буюу 6.6 хувь, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 49 буюу 16.2 хувь, харъяаллын дагуу бусад газарт 7 гомдол мэдээлэл шилжүүлсэн нь 2.3 хувьтай шийдвэрлэж гомдол мэдээллийн үлдэгдэлгүй байна. Нийт шалгасан гомдол мэдээллийн 100 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэжээ.

Тус 0-ийг хэмжээнд урьд оны үлдэгдэл 7 хэргээс 6 хэргийг шүүхэд шилжүүлэх, бусад Цагдаагийн газарт харьяаллын дагуу 1 хэргийг шилжүүлж үлдэгдэл хэрэггүй байна.

2019 онд мөрдөн байцаалтын 293 үйлдэлтэй, 284 холбогдогчтой, эрүүгийн 252 хэрэг шалгаж, 197 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай шийдвэрлэж 78.1 хувьтай, 14 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэж 5.5 хувьтай, 35 хэргийг бусад хэрэгт нэтгэн шийдвэрлэж 17.6 хувьтай, хэрэгсэхгүй болгох саналтай 2 хэргийг шийдвэрлэсэн нь 13.8 хувь, одоо ажиллагаанд 4 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь 2.7 хувьтай шийдвэрлэсэн ба нийт хэргийн шийдвэрлэлт 97.2 хувьтай байна. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргээс түдгэлзүүлсэн хэрэг байхгүй.

2019 оны байдлаар урьд оны үлдэгдэл хэрэг бүртгэлтийн 16 хэрэг байсан ба үүнээс хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан 11, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 5 хэрэг байгаа ба одоо ажиллагаанд урьд оны үлдэгдэл байхгүй байна.

Энэ оны байдлаар хэрэг бүртгэлтийн 87 үйлдэлтэй, 68 холбогдогчтой, 282 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгасанаас 157 хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай шийдвэрлэж 55.6 хувьтай, 86 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 30.4 хувьтай, харьяаллын дагуу 10 хэргийг шилжүүлж шийдвэрлэж 3.5 хувьтай, одоо ажиллагаанд 29 хэрэг байна. Нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт 89.7 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргүүдэд иргэд байгууллагад учирсан 1315984710 төгрөгний хохирлыг нөхөн төлүүлсэн нь хохирол нөхөн төлүүлэлт 61.8 хувьтай байгаа ба иргэний нэхэмжлэл, торгох ял, эд хөрөнгө хураах байдлыг хангах зорилгоор иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшлийн нийт 153347468 сая төгрөгний үнэ бүхий үй хөрөнгийг битүүмжилсэн.

Мөрдөн байцаах тасагт ажиллагаанд шалгагдаж байгаа хэргийн шийдвэрлэх графикыг бүр гаргаж Аймгийн прокурор, Цагдаагийн газрын дарга нараар батлуулан гүйцэтгэлийг тооцож ажиллаж байна. Энэ онд шүүхээс 13, прокуророос 20 хэрэг буцсан.

Тасгийн хэмжээнд өмнөх оны үлдэгдэл хэргүүдийг шийдвэрлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацаа сунган шалгагдаж байгаа эрүүгийн хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх зорилгоор шүүх, прокурорууд болон мөрдөгч нарын өргөтгөсөн зөвлөгөөн, ажлын уулзалтыг 5 удаа, “Шийдвэрлэлт 21”, “Шийдвэрлэлт 2” аянуудын хүрээнд урьд оны үлдэгдэл, хугацаа сунгасан хэргүүдийг шийдвэрлэх зорилгоор 3 удаа ажлын уулзалт зохион байгуулж хамтран ажиллаж цаашид хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх хэргүүдийг ярилцаж санал солилцох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

2019 оны байдлаар цагдан хорих байранд сэжигтэн, яллагдагчаар нийт 32 бүнийг шинээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, одоо 2 хүн цагдан хоригдон шалгагдаж байна.

Тайлангийн хугацаанд бусад газарт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар мөрдөгчийн 54 даалгавар хүргүүлж, хариуг 100 хувь авч ажилласан. Мөн бусад газраас ирүүлсэн мөрдөгчийн 94 даалгаврыг хүлээн авч, хугацаанд нь зохих ажиллагааг хийж гүйцэтгэн хариуг хүргүүлсэн.

Мөн ажиллагаанд шалгагдаж байгаа болон шийдвэрлэсэн нийт 203 хэрэгт мөрдөгчийн мэдэгдлийг бичиж холбогдох албан тушаалтанд хүргүүлэн хугацаанд хариуг шаардаж ажилласан ба үүнээс 182 мэдэгдлийн хариуг шаардаж авсан, 21 мэдэгдлийн хариу ирүүлэх хугацаа болоогүй байна.

0-ийг дарга, ахлах мөрдөгч нар мөрдөгч нарын хугацаа сунган өмнөх хэргээс 6 хэргийг шүүхэд шилжүүлэх, бусад Цагдаагийн газарт харьяаллын дагуу 1 хэргийг шилжүүлж үлдэгдэл хэрэггүй байна.

10ддэг шалгах ажиллагаанд байгаа хэрэг нэг бүртэй танилцан 43 хэрэгт бичгээр зааварчилгааг өгч биелэлтийг тооцсон.

Мөрдөгч нараас хүлээн авсан хэрэг материалуудад шалгах төлөвлөгөө, түүвэрийг тухай бүр тасгийн даргаар хянуулж батлуулж байх ажил хэвшил болж, албанаас ирүүлсэн үүрэг ажлын чиглэлүүд, албаны даргын 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01 дугаартай албан даалгаврын дагуу шалгаж байгаа хэрэг бүрийн түүвэрийг “Од” программын түүвэр шалгах төлөвлөгөөний хэсэгт 534 хэргээс 514 хэргийн шалгах түүвэр төлөвлөгөөг шивж оруулаад байна. Мөн хугацаа дууссан гэх зөрчилтэй байсан 154 хэргийн шалгах түүвэр төлөвлөгөөг засварлан зөрчлийг арилгасан. Мөн алба хаагчдад шалгах түүвэр төлөвлөгөөний учир холбогдлыг ойлгуулах зорилгоор ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Бадрал 1 удаагийн 2 цагийн сургалт зохион байгууллаа.

Эрүүгийн хэрэг үүсгэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тасаг, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарыг аймгийн хэмжээнд бүсэд хувааж, ахлах мөрдөгч нарт хувиарлан өгч, гэмт хэрэг гарсан үед багаар ажиллуулах байдлаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр бусад тасаг албадтай хамтран “Шинэ жил”, “Сар шинэ-2019”, “Нуугдмал”, “Залилах гэмт хэргийн Оргодол-Шийдвэрлэлт” арга хэмжээнүүдийг зохион байгуулж, “Сар шинэ-2019” нэгдсэн арга хэмжээний дүнгээр тус Цагдаагийн газар нь улсын хэмжээнд 2 дугаар байр орсон амжилт үзүүлсэн.

Харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Миний монгол” телевизтэй хамтран зохион байгуулсан “Ярилцах цаг” нэвтрүүлэгт Сэлэнгэ аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газрын ажилтан нартай хамтран “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний талаар мэдээлэл өгч арга хэмжээний хүрээнд ямар ажил арга хэмжээ зохион байгуулж ажиллаж байгаа, иргэд хэрхэн хамтран ажиллах, гэмт хэргийн үйлдэгддэг арга, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга замын талаарх мэдээлэл, ярилцлагыг өгч, иргэд, олон нийтэд энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийн талаар мэдээлэл хүргэсэн.

Мөрдөн байцаах албанаас 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн 9 төрлийн 45 ширхэг санамж сэрэмжлүүлэгийг иргэдэд тарааж, 2 төрлийн 20 ширхэг зурагт хуудсын аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.

Улсын хэмжээнд зохион байгуулсан “Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэл-2019” арга хэмжээн хүрээд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэргийн шинжтэй 18 гомдол мэдээлэл хүлээж авч, 3 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан, 14 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 1 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай шийдвэрлэсэн. Нийт 27 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас 11 хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн, 8 хэрэг бүртгэлтийн хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн, 8 хэрэг ажиллагаанд үлдэгдэлтэй байна. Нийт мөрдөн байцаалтын 23 хэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. Үүнээс 20 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 2 хэргийг нэгтгэж шийдвэрлэсэн, 1 хэргийг харьяаллаар Архангай аймаг дахь Цагдаагийн газарт шилжүүлж ажилласан байна.

2.4. Хэрэг бүртгэх тасгийн үйл ажиллагааны чиглэлээр: Тус тасаг нь 2019 оны 11 дүгээр сарын байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 167 гомдол мэдээлэл хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бөгөөд нийт

хүлээн авч шалгасан гомдол мэдээллийн 92-д нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 30 гомдолд эрүүгийн хэрэг үүсгэж, 4 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж, 41 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Хэрэг бүртгэлтийн 153 хэрэг шалгаснаас 99 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 35 хэргийг хаах санал прокурорт хүргүүлж, одоо ажиллагаанд 14 хэрэг бүртгэлтийн хэрэг байна.

Мөн 168 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсанаас 156 холбогдогчтой 152 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай хүргүүлж, 2 хэрэг нэмэлт ажиллагаа хийлгүүлхээр шүүх, прокуророос буцсаныг шийдвэрлэсэн, 1 хэргийг нэгтгэсэн одоо ажиллагаанд 6 хэрэг байна.

Мөн 2019 оны 11 дүгээр сарын байдлаар Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заагдсан 152 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхэд шилжүүлэх саналтай хүргүүлсэн бөгөөд дээрх хэргүүдийн шалтгаан нөхцөлийн арилгуулахаар мөрдөгчийн мэдэгдлийг 100 хувь бичиж 107 мэдэгдлийн хариуг авч биелэлтийг тооцон ажиллав.

Тасгийн даргын зүгээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 61 хэрэгтэй уншиж танилцан, алба хаагчдад 23 зааварчилга, 2 даалгавар бичиж биелэлтийг тооцон ажилласан.

Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан 163 сая төгрөгийн хохирлоос хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд 154 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласан. Нөхөн төлүүлэлт 94,4 хувьтай байна.

Тус тасаг нь 2018 оны үлдэгдэл 7, 2019 онд шинээр 14, нийт 21 хүнийг Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” санд эрэн сурвалжилж ажиллаж байсан ба үүнээс 19 этгээдийг хаана байгаа газраас нь олж тогтоон эрэн сурвалжлах ажиллагааг зогсоосон.

Тус тасаг нь сард шийдвэрлэх хэргийн графикийг тухай бүр шинэчлэн гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулан аймгийн прокурорын газар, хэрэг бүртгэх албанд хүргүүлж хэвшсэн. Ээдрээ төвөгтэй болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд удааширсан хэргийг шийдвэрлэх зорилгоор аймгийн прокурорын газартай хамтран 2019 оны 06 дугаар сарын 06-ний өдрөөс 06 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд “Шийдвэрлэлт-21 хоног” аяныг зохион байгуулж үр дүнг тооцож ажилласан. Мөн мөрдөгч нарын гаргаж байгаа нийтлэг алдаа, зөрчлийг арилгуулах ЭХХШТХ-ийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор 2019 оны 01 дүгээр сарын 31, 06 дугаар сарын 5, 10 дугаар сарын 08, 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд буюу нийт 4 удаа прокурорын байгууллагатай хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цахим мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулах, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэлд бүрэн дүүрэн хяналт тавьж, алба хаагчдыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргүүдэд хийгдсэн ажиллагаа болгоны талаарх маягтыг мэдээллийн санд тэр дариу шивж оруулах, “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код-701/журам”-ын хэрэгжилтийг хангах талаар үүрэг өгч, биелэлтэнд нь биечлэн хяналт тавьж, “Хянагдсан” төлөвт оруулан ажиллаж байна.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Нэг хором” аян зохион байгуулах салбар төлөвлөгөөг боловсруулан аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн даргаар батлуулан 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран сургагч багш Б.Батцэцэгийг урьж аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын 300 ажилтан, албан хаагчдад “Эерэг сэтгэлгээ, хандлагын боловсрол” сэдвээр нөлөөллийн сургалт зохион байгуулсан. Мөн Мандал суманд

үйл ажиллагаа явуулж буй цэрэгжүүлсэн байгууллагын 250 алба хаагч, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 500 сурагчдад уг аяны утга, мөн чанарын талаар яриа таниулга хийж “Нэг хором” аяны “Ухаалаг залуус амьдрал аварна” нэгдсэн урианд нэгдүүлж, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай 3 төрлийн 1200 ширхэг зурагт хуудсыг тарааж ажилласан. Мөн зохион байгуулж байгаа аяны талаарх мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилж ажиллав.

Гэмт хэрэг, зөрчлийн хор уршиг, холбогдогчид хүлээлгэх хариуцлагын талаар болон ялангуяа хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд хоорондын харилцааны асуудал чухал үүрэгтэй талаар болон цагдаагийн байгууллагаас “Шинэ жил”, “Сар шинэ-2019”, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр зохион байгуулсан “Нэг хором” аян, Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд”, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ойлгоё-Хүндлэе” зэрэг нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байгаа талаар болон бусад хэлбэрээр ярилцлагыг орон нутгийн “Миний Монгол” телевизэд 11 удаа өгч, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай 18 төрлийн видео, шторкыг нэвтрүүлэн, энэ тухай бичлэг, контентийг “Сэлэнгэ цагдаагийн газар” facebook хуудсанд байршуулан ажиллав.

Хууль зүй дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/63, А/48, А/106 дугаар хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор эрүүлжүүлэх саатуулах байранд захиргааны журмаар баривчлагдсан 21 хүнд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлага” сэдвээр 8 удаа тус бүр 30 минутын нөлөөллийн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, тэмдэглэл үйлдэв.

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 86 дугаар тушаалаар жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийг “Хуульчдын Про Боно өдөр” болгон зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу аймгийн төв “Партизаны талбай”-д тус арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүллээ.

Арга хэмжээний үед хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс сэргийлэх чиглэлээр “Уураар биш ухаанаар шийд”, “Нэг цохилт нэг амьдрал сүйтгэнэ”, “Хормын уур хожмын амьдралыг сүйтгэнэ”, “Нэг хормын уур, нэг насны харуусал” сэдэвт 4 төрлийн 100 ширхэг санамж, сэрэмжлүүлгийг бэлтгэн иргэдэд тарааж, иргэдээс ирүүлсэн 6 санал, 40 хүсэлт, 2 гомдлыг хүлээн авч, газар дээр нь 47 асуудалд зөвлөгөө өгч шийдвэрлэн, 1 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлсэн.

Хэрэг бүртгэх албанаас санаачилсан “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт хэлэлцүүлгийг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд тус Цагдаагийн газраас аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт оролцогчдоос 5 чиглэлийн ажил арга хэмжээ зохион байгуулахаар хэлэлцэн гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 2019 оны эхний хагас жилийн биелэлтийг гарган Хэрэг бүртгэх албанд хүргүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн хүрээнд “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” ихээр үйлдэгддэг, үйлдэгдэж болзошгүй

эмзэг цэгийн судалгааг тухай бүр шинэчлэн гаргаж, Цагдаагийн газрын мэдээлэл судалгааны мэргэжилтнээс ирүүлсэн нөхцөл байдлын судалгаанд дүн шинжилгээ хийж Нийтийн хэв журам сахиулах эргүүлийн цаг байршилтанд улирал бүр санал өгч эргүүл, шалгалтаар хамтран ажилласны үр дүнд “Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг”-ийн гаралт аймгийн хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 169 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 67 хэргээр буюу 28,3 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Тус Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах, Эрүүгийн цагдаагийн, Нийтийн хэв журам хамгаалах, Замын цагдаагийн тасгууд хамтран “Иргэн танд тусалъя” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр “Сэлэнгэ Олон улсын худалдааны төв”-д зохион байгуулж, тус тасгаас Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хор уршиг, Хүүхдийн эрхийг хамгаалах, насанд хүрээгүй хүнийг гэмт хэргийн хохирогч, холбогдогч болохоос урьдчилан сэргийлэх, эцэг эхчүүдийн дунд хүүхэд хамгааллын ажлыг эрчимжүүлэх зэрэг чиглэлээр материал бэлтгэн иргэд, олон нийтэд сурталчлан түгээж ажилласан.

Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, хуульч ажиллагааг сайжруулах зорилгоор тайлангийн хугацаанд 1 алба хаагчийг “Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн байгууллагын оролцоо” сэдэвт, 1 алба хаагчийг АНУ-ын элчин сайдын яамнаас Аймгийн гаалийн газартай хамтран зохион байгуулсан “Иргэний бичиг баримтыг шалгах, тэдгээрийн нууцлал” сэдэвт сургалтанд тус тус хамрууллаа.

2.5. Нийтийн хэв журам хамгаалах тасгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тус Цагдаагийн газраас захиргааны хяналтанд шүүхээс тэнсэн харгалзах ялаар шийтгэгдсэн 10 этгээдэд захиргааны хяналт тогтоож ажилласнаас хугацаа дууссан үндэслэлээр 9-ийг зогсоож 1 этгээдэд хяналт тавьсан. Хорих ялаас тэнсэн суллагдсан 6 этгээдэд хяналт тавьж хугацаа дууссан үндэслэлээр 4 этгээдэд тавих хяналтыг зогсоож 2 этгээдэд хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн төвд хорихоос хугацааны өмнө суллагдсан 1 этгээд, Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст шүүхээс тэнсэн суллагдсан 1 этгээд, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст хорихоос хугацааны өмнө тэнсэн суллагдсан 1 этгээд нийт 3 этгээдэд хяналт тавьж ажиллаж байна. Захиргааны хяналтыг сайжруулах зорилгоор сар бүр хяналтын прокурор, удирдах ажилтуудад хувийн хэргүүдийг танилцуулах хуваарийг шинэчлэн гаргасан.

Зохион байгуулсан нэгдсэн, тусгай арга хэмжээний хүрээнд: Аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо баримтанд тулгуурлан тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг зөрчлийн гаралтыг саармагжуулах чиглэлээр Цагдаагийн Ерөнхий газрын төрөл мэргэжлийн албадаас зохион байгуулсан 6 нэгдсэн арга хэмжээ, сум орон нутагт 6 хэсэгчилсэн арга хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулан ажиллаж, уг арга хэмжээнүүдэд 11 төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулаад байна.

Тайлангийн хугацаанд Цагдаагийн Ерөнхий газрын төрөл мэргэжлийн албадаас, “Сэрэмжлүүлэг-1”, “Сэрэмжлүүлэг-2”, “Сэрэмжлүүлэг-3” “Зөрчил”, “Сэргийлэх”, “Мялзан” “Урьдчилан сэргийлэх”, “Цэрэг татлага-2019”, “Хамгаалалт” зэрэг арга хэмжээнүүдийг залилах, танхайрах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж сэрэмжлүүлэг 2500 тарааж, 1200 хүнд яриа таниулга хийж ажиллалаа.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаар: Нийтийн хэв журам хамгаалах тасагт 2019 онд нийт 1013 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл

бүртгэгдсэнээс харъялалын дагуу шилжүүлсэн 34, хүлээн авахаас татгалзсан 444, зөрчлийн хэрэг нээсэн 214, зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 439, одоо ажиллагаанд байгаа 37 гомдол мэдээлэл байна. Зөрчил гаргасан 400 иргэнийг шүүхээр 7-30 хоног баривчлуулж шийдвэрлэсэн байна.

Машинт болон явган эргүүлийг мэргэжлийн удирдлагаар хангах, илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар: Нийтийн хэв журам сахиулах эргүүлд давхардсан тоогоор 8157 алба хаагч 65256 хүн/цагийн үүрэг гүйцэтгэх хугацаанд Шуурхай удирдлагийн тасгаас 1414 дуудлага мэдээлэл хүлээн авч, зөрчил гаргасан 1675 иргэнийг албадан саатуулж, 1046 зөрчил илрүүлж гудамж талбай олон нийтийн газарт согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж бие авч явах чадваргүй 356 иргэнийг ар гэр, асран хамгаалах хүнд нь хүлээлгэн өгч, давхардсан тоогоор тэсэрч дэлбэрэх, химийн хорт бодис үйлдвэрлэдэг, хадгалдаг 708, банк санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх газар 1904, үйлчилгээний газар 14980, Их дээд сургууль, МСҮТ 284, ерөнхий боловсролын сургууль 1164, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага 216, асрамж, халамжийн газар 200 бусад аж ахуйн нэгж байгууллагын харуул манаа 17076 тус тус шалгаж ажилласан.

Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд 90 гэмт хэргийг илрүүлж, 23 гэмт хэргийг таслан зогсоож, оршин суугаа газраасаа сураггүй алга болсон 73 иргэнийг эрэн сурвалжлаж 57 иргэнийг урьд онуудын үлдэгдэл 28 нийт 85 иргэний хаяг байршлыг тогтоож хариуцсан шүүхүүдэд албан бичгээр хариуг хүргүүлсэн, Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргон зайлсан 14 иргэнийг хаяг байршлыг олж тогтоон саатуулж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгсөн. Мөн эрэн сурвалжилсан галт зэвсэг 7, мал 9 олж хариуцсан алба хаагчид нь хүлээлгэн өгч, 1084 зөрчил илрүүлэн, зөрчил гаргасан 1046 иргэнийг 12 266 000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 1742 иргэний албадан эрүүлжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 4500 иргэнд яриа таниулга хийж 1095 санамж сэрэмжлүүлэг, 2960 зурагт хуудас, 850 гарын авлага тараасан.

Хэв журмын хамгаалалтын ажлын хүрээнд: Тус тасгаас 2019 онд дараах хэв журмын хамгаалалтыг зохион байгуулж ажилласан. Үүнд:

Тус цагдаагийн газраас Аймгийн хэмжээнд нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, урлаг, спортын арга хэмжээ, төрийн тусгай хамгаалалт болон гадаадын зочид төлөөлөгчийн айлчлалын үеийн хамгаалалт зэрэг нийт 86 удаагийн 7433 цагийн хугацаатай үргэлжилсэн хамгаалалтад давхардсан тоогоор 1590 алба хаагч 48346 хүн цагийн үүргийг гүйцэтгэж, тухай бүр хамгаалалтын төлөвлөгөө зураглалыг гарган, алба хаагч нарт аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, биелэлт үр дүнг тооцон, Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд шивж оруулан ажилласан.

Арван долдугаар жарны “Урвуулагч” хэмээх шороон гахай жилийн сар шинийн баяр, амралтын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан төв орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн дарга нарт Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүрэг ажлын чиглэлийг хэрэгжүүлэх талаар Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэглэлд шилжүүлэн ажиллуулах тухай Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/60 дугаар тушаалыг Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд танилцуулж, Цагдаагийн газрын даргын өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэглэлд шилжүүлж ажиллуулах тухай 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/07 дугаартай тушаалыг гарган Мандал, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллав. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед Цагдаагийн газрын нийт 256 алба хаагч ямар нэгэн зөрчил дутагдалгүй үүргээ гүйцэтгэсэн.

Саатуулах байрны ажлын талаар: 2019 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар согтуугаар зөрчил гаргаж аймгийн төвд 702, Мандал суманд 831, Сайхан суманд 209 нийт 1742 хүн эрүүлжүүлэгдэж, 1742 иргэнээс 7.229.300 төгрөгийн хураамж, баривчлагдсан 400 иргэнээс 11149650 төгрөгийн хураамж тус тус авч төрийн сангийн дансанд тушаасан.

Зөвшөөрлийн системийн талаар: Тус Цагдаагийн газарт бүртгэлтэй 1110 галт зэвсэг, 9 галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 1066 галт зэвсэг, 9 галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл бүртгэж, галт зэвсэг 96, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл 100 хувьтай тус тус тоологдож, 56 галт зэвсгийг бусад төв орон нутгийн Цагдаагийн газар, хэлтэс рүү шилжүүлж, Цагдаагийн байгууллагын цахим сангийн “Од” программд оруулан, тус санд давхардсан 7 галт зэвсгийг сангаас хасалт хийлгэн ажилласан. Галт зэвсгийн гэрчилгээг 2019 онд нийт 83 иргэд олгож, нийт галт зэвсгийн гэрчилгээний үнэ болох 398.400 төгрөгийг холбогдох дансанд тушаалгаж ажилласан.

Монгол улсын “Галт зэвсгийн тухай хууль”-ийг зөрчсөн 30 иргэнийг “Зөрчлийн тухай хууль”-ийн 5.6 дугаар зүйлээр 4.580. 000 төгрөгөөр торгож арга хэмжээ авч, хууль эрх зүйн зөвлөгөөг өгсөн.

Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулдаг гэрээт харуул хамгаалалтын 3 тусгай зөвшөөрлийг сунгасан ажиллалаа.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангаж чиглэлээр: Шүүхийн байрыг байнгын хамгаалалтанд байлгаж, шүүгчийн аюулгүй байдлыг ханган давхардсан тоогоор 12249 иргэнийг хамгаалалтын бүсэд шалган нэвтрүүлж холбогдох баримт бичгийг үндэслэн бүртгэж хяналт тавьж ажилласан.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцлийг бүрдүүлж төвийн алба хаагчид эрүүгийн 505, иргэний 542, захиргааны хэргийн 86, зөрчлийн 182, Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн алба хаагчид эрүүгийн 437, иргэний 340, зөрчлийн 200 шүүх хурал, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн алба хаагчид эрүүгийн 170, иргэний 143 зөрчлийн 107 хурал нийт 2712 шүүх хурал хуралдаж шүүх хуралд хамгаалалтыг зохион байгуулсан. Харьяа шүүхээс албадан ирүүлэхийг даалгасан 38 захирамж хүлээн авч захирамжийн биелэлтийг бүрэн хангаж ажилласан.

Алба хаагчид аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байрнаас шүүхэд 134 удаа 156 яллагдагч, шүүгдэгчийг, Шүүхийн байрнаас Цагдан хорих байранд 198 удаа 234, Улаанбаатар хотруу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 1 яллагдагчийг хуяглан хүргэж нийт 333 удаа 391 яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэж. Хуяглан хүргэх ажиллагааг журмын дагуу зохион байгуулж ажиллагааны явцад алба хаагчдын болон яллагдагч, шүүгдэгчийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

2.6. Замын цагдаагийн тасгийн үйл ажиллагааны чиглэлээр: Тус аймгийн нутаг дэвсгэрт 2019 онд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг, осол 147 бүртгэгдсэн байна. Үүнээс: зам тээврийн хэрэг 55, осол 92 гарсанаас, хүний амь нас хохирсон 26, гэмтсэн 59 хүн байна.

Тус тасгийн алба хаагч нар гудамж замд хяналт шалгалтаар 23607 зөрчил илрүүлж, үүнээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт зөрчил 1027, эрхийн үнэмлэхтэй согтуугаар жолоодсон 807 жолоочийг 322.800.000 төгрөг, эрхийн үнэмлэхгүй буюу эрхээ хасуулсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 220 жолоочийг шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчилсан, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 995 жолоочийг 199.900.000 төгрөгөөр, зөрчлийг газар дээр нь бэлэн бусаар 21632 жолоочийг 550.405.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авч ажилласан байна.

Тус Цагдаагийн газрын Замын цагдаагийн алба хаагчид “Шинэ жил”, “Цагаан сар”, “Авто машин-2019”, “Бяцхан зорчигч”, “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2019”, “Бяцхан зорчигч”, “Яараад яахав дээ”, “Дураараа биш ээ Дүрмээрээ”, “Хичээлийн шинэ жил”, “Илрүүлэлт Оргодол Шийдвэрлэлт”, “Зэвсэг”, “Хальтиргаа гулгаа” зэрэг нэгдсэн арга хэмжээ болон аяны хүрээнд зохион байгуулсан ажилыг олон нийтэд сурталчилах зорилгоор нэвтрүүлэг-13, шторк-16 бэлтгэн орон нутгийн “Миний Монгол”, “Эрдэнэ” кабелийн телевизээр сурталчилан 99 аж ахуйн нэгж байгууллагын 2500 ажилтанд яриа таниулга хийж ажилласан.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхааны 4 зам, Баянгол, Мандал, Сайхан сумын “Хөтөл” постууд 24 цагаар замын хөдөлгөөнд тогтмол хяналт тавин ажиллаж, зам тээврийн хэрэг, осол үйлдэгдэж болзошгүй /хар цэг/ газар болох Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Бороогийн гүүр” Баянгол сумын “Хадагтай мод”, “Гонир” 3 дугаар баг Баянцогтын ар, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын “Зараагийн хөндий” “Ноорбуу”-н тойрог, Шаамар сумын “Нарс”, “Ар гангатын даваа”, “Ерөөгийн даваа” зэрэг газруудад хурд хэмжигч багажтай хяналт шалгалтыг Хюндай Элентра маркийн 0024 сээ, 0025 сээ, 0608 сүү, Хюндай Аксент маркийн 0101 сээ, 0100 сээ улсын дугаартай албаны тээврийн хэрэгслүүдээр тодорхой цагуудад хөдөлгөөнтөөр гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалт хийж ажиллаж байна.

ЗИЛ-131 маркийн 91-34 СЭҮ улсын дугаартай тээврийн хэрэгслийг Сайхан сумын Номгон 3 дугаар багийн нутагт Дархан-Уул аймгаас Орхон аймгийн чиглэлийн төв хатуу хучилттай асфальтан замын 39-40 дэхь км-т байрлуулан зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил арга хэмжээ зохион байгуулан ажиллалаа.

Замын цагдаагийн тасаг зам тээврийн хэрэг ослоос урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл түгээх зорилгоор олон нийтийн “Сэлэнгэ Цагдаагийн газар”, “Орон нутгийн замын цагдаа”, “Хөтөл цагдаа”, “Мандал цагдаа” зэрэг цахим хуудсанд замын нөхцөл байдал, нэгдсэн арга хэмжээний талаар алба хаагчид давхардсан тоогоор 116 удаа мэдээ, сэрэмжлүүлгийг байршуулсан байна.

Тус аймгийн Баянгол сумын нутаг дэвсгэрийн төв замд “Баян чандмань-АЗЗА” ТӨХК-ний тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, техникийн стандартыг хангуулах зорилгоор үзлэг шалгалт зохион байгуулж ажилласан. “Баян чандмань-АЗЗА” ТӨХК нь Тахилтын давааны халтиргаа, гулгаа үүссэн үед, зам давааны цас мөсийг хусаж арилгуулж байна. “Дархан АЗЗА” ТӨХК нь зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хустайн давааны зам дээр үүссэн цас мөсийг цэвэрлүүлж, давааны замын хажууд элс бэлдэн овоолон ажиллаж байна.

“Орхон АЗЗА” ТӨХК нь Хөшөөтийн давааны төв зам дээр үүссэн цас мөсийг арилгаж, давааны замын хажууд элс бэлдэн овоолгож ажилласан. Хариуцсан замыг АЗЗА ТӨХК-уд нь зам дээр үүссэн эвдрэл /хагархай/-ийг нөхөн засварлаж, замын хажуугийн хөвөөн дээр шороо асган тэгшлэж, замын тэмдэг тэмдэглэлийг сэргээн засварлан ажилласан. Сүхбаатар сумын гэрэл гэрэлтүүлэг, замын тэмдэг тэмдэглээнний судалгааг шинэчлэн гаргаж, 2019 оны 10 дугаар сард “Сэлэнгэ Азза” ТӨХК-ны өвөлжилтын бэлтгэлийг шалган нөөцөлсөн бодис, давс, элс, шороо болон техник хэрэгсэлтэй танилцсан.

Зам тээврийн осол бууруулах чиглэлээр тус тасгаас Техник, Замын хяналтын хэлтсийн календарьчилсан төлөвлөгөөний дагуу Сар шинэ-2019, Сар шинэ гэрээгүй тээвэр, “Тусгай дуут болон гэрлэн дохио”, “Хурд”, “Хүнд даацын авто машин, оч баригч”, “Автомашин-2019”, “Мотоцикль-2019”, “Ачааны автомашин бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт” “Замын тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал”, тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа, дуу чимээ илэрхий зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгсэлд хяналт” “Улсын дугаар” “Бяцхан зорчигч” хэсэгчилсэн арга хэмжээ мөн Улсын хэмжээнд зохион

байгуулагдаж байгаа “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулан Орон нутгийн “Миний Монгол” кабелийн телевиз шууд дамжуулан иргэд олон нийтэд түгээсэн ба Сэлэнгэ Цагдаагийн газар, Сэлэнгэ зар, Орон нутгийн замын цагдаагийн цахим хуудсанд тус бүр 36 удаа байршуулсан.

Зөрчлийн тухай хуулийн 14.7-р зүйлийн 10.1 заалтын дагуу 36 жолоочийг 1.800.000 төгрөг, 10.2 заалтын дагуу 1356 жолоочийг 67.800.000 төгрөгөөр, 10.3 заалтын дагуу 30 жолоочийг 1.500.000 төгрөгөөр торгож торгуулийн арга хэмжээ авсан байна.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК албан мэдэгдэл хүргүүлэн А0401, А0402, А0403 дугаартай авто замуудын эврэл гэмтэл болон замын хөвөөний бохирдсон хэсэг, хог хаягдлыг цэвэрлэх, засварлах ажлыг зохион байгуулсан.

Зам тээврийн гэмт хэрэг, осол үйлдэгддэг, үйлдэгдэж болзошгүй газраар анхаарал болгоомжтой явах талаар Орон нутгийн замын цагдаа, Сэлэнгэ цагдаагийн газар, Мандал Цагдаагийн хэлтэс, Хөтөл цагдаа, Сэлэнгэ зар, Хөтөл зар, Сэлэнгэ зар зэрэг цахим хуудсанд нийт 54 удаа 6 төрлийн 12000 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, /хурдаа тохируул, хамгаалах бүс хэрэглэ, хүүхдийг зөв тээвэрлэе, согтуугаар тээврийн хэрэгсэл бүү жолоод, тээврийн хэрэгсэл жолоодох үедээ гар утсаар бүү оролд/ бэлтгэн нийтэлсэн байна. Зам тээврийн ослыг бууруулах чиглэлээр тус тасгаас Тээврийн цагдаагийн албаны Техник, замын хяналтын хэлтсээс зохион явуулахаар гаргасан календарьчилсан төлөвлөгөөний дагуу “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэл гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тусгай дуут гэрлэн дохио”, “Хурд”, “Хүнд даацын авто машин, оч баригч”, гэсэн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллалаа.

Дархан-Уул аймгаас Орхон аймгийн чиглэлийн төв хатуу хучилттай замд хяналт шалгалт хийж Сайхан сумын орон нутгийн телевизтэй хамтран зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа хийж жолооч, зорчигч нарт 4 төрлийн 2250 ширхэг санамж сэрэмжлүүлэг, зурагт хуудас, Улаанбаатар хотоос Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн чиглэлийн төв хатуу хучилттай замд Мандал сумын орон нутгийн телевизтэй хамтран зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж 9 төрлийн 8100 ширхэг санамж, сэрэмжлүүлэг зурагт хуудсыг тус тус тараан ажилласан. Замын цагдаагийн алба хаагчид хариуцсан 5 аж ахуй нэгж, байгууллагад Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмээр 312 иргэнд яриа таниулга хийж мэдээлэл өгсөн.

Замын цагдаагийн тасгийн алба хаагчдаас 2019 онд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах явцад 2 гэмт хэрэг илрүүлж, цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” сангаар эрэн сурвалжлагдаж байсан 13 оргодлыг олж тогтоон, хууль бусаар ан агнасан, хууль бусаар гарал үүслийн гэрчилгээгүй мод тээвэрлэсэн 11 хэргийг, бичиг баримтгүй нуугдмал галт зэвсэг 2-ыг тус тус илрүүлэн холбогдох алба хаагч нарт хүлээлгэн өгч ажиллажээ.

Аймгийн Замын хөдөлгөөний дүрмийн шалгатанд 2297 сонсогч хамрагдаж 1707 нь тэнцэж, 590 нь тэнцээгүй байна.

Замын хөдөлгөөний дүрмийн шалгатанд 1707 сонсогч тэнцсэнийг жолоочийн үнэмлэх авахуулах материал, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 945 жолоочийн материал, үнэмлэх солиулах 615 иргэний материалыг тус тус бүрдүүлэн Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвд хүргүүлээ.

2.7. Шуурхай удирдлагын тасгийн үйл ажиллагааны чиглэлээр: Тус тасгаас 2019 онд албаны чиг үүргээ гүйцэтгэхдээ Цагдаагийн ерөнхий газрын

Шуурхай удирдлагын штаб, Мэдээлэл шуурхай удирдлагын төвд, тодорхой цагуудад тогтмол нөхцөл байдлаа, гарсан гэмт хэрэг, зөрчлийн мэдээ мэдээллийг Цагдаагийн газрын удирдлагад тус тус танилцуулж, оiö öĳiä äyìð öýðyā āāðñāi òòòāè áĳòт àèāāāüí öýèāāā òìèāīñā òāiāāæ ýðýí òòðāāèæèāð çāðèèi ÿāýýèèèèā íèèð бие áĳðýèāýöĳĳiä ýāðāèðāè òĳāýýæ, òāāèð, āīīèð òèèð çýðýā òìèèèòèèèāĳé àæèèèāāāā, çìèèíí āāèāòòèèèèòòн арга хэмжээä àâ÷ àæèèèàлаа.

Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт хувийн болон албан ажлаар явж буй нийт 1156 алба хаагчдад тухайн газар, хэлтсийн жижүүрийн мөрдөгч нараас аюулгүй байдлаа хангаж явах талаар зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулан, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг замын зохицуулагчаар шалгуулан тэмдэглэл үйлдэн ажилласан.

Шуурхай удирдлагын тасагт Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-200/-д заасан хөтлөгдвөл зохих бүртгэл судалгааг шинэчлэн, онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөө, албаны бэлэн байдлын төлөвлөгөөнүүдэд улирал бүр тодотгол хийж холбогдох албан тушаалтнуудаар батлуулан албаны бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд тасгийн даргаас алба хаагч нарт нийт 29 зааварчилгаа, зөвлөмж өгч, бусад алба газар тасгаас ирсэн 193 албан бичгийг бүртгэн, хариутай бичгийг хугацаанд нь хариу өгч шийдвэрлэсэн байна.

2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 08:00 цагаас 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05:00 цагийн хооронд Шуурхай удирдлагын тасаг нь иргэд байгууллагаас өргөдлөөр болон тухайн байгууллагын утсаар нийт 3184 дуудлага мэдээлэл хүлээн авсан. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 802 дуудлага мэдээллийг хүлээн авч хэргийн газрыг хамгаалалтад авахуулж, үзлэгийн багийг удирдан зохион байгуулж, хойшлуулшгүй ажиллагааг хууль журмын дагуу хийж гүйцэтгэсэн. Зөрчлийн шинжтэй 2128, бусад 254 дуудлага мэдээлэл хүлээн авч дуудлага мэдээлэл бүрт түргэн шуурхай цаг алдалгүй богино хугацаанд очиж ажилласан байна.

Мэдээлэл шуурхай удирдлагын төв болон, иргэдээс ирүүлсэн улсын болон аймгийн хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-229/-ыг мөрдлөгө болгон хүлээн авч тэмдэглэл хөтлөн холбооны хэрэгслээр болон эрэн сурвалжлах “АСАП”-санг ашиглан Цагдаагийн газрын алба хаагчид болон Мандал, Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа болон хэв журам сахиулах эргүүл, замын цагдаагийн эргүүл, постуудад зарлан мэдээлж Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай хүргэж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллалаа.

Тус цагдаагийн газар, Мандал, Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээ, сүлжээний тоног төхөөрөмжийн ашиглалт, хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавьж гарсан гэмтэл саатлыг тухай бүр холбоо мэдээллийн инженер засварлан ажиллаж байна. Цагдаагийн Ерөнхий газраас алба хаагч нар үйл ажиллагаандаа ашиглах бэлэн бус торгуулийн төхөөрөмж болох 7 гар утас, 1 таблетыг дагалдах хэрэгслийн хамт тасгийн алба хаагч нарт бүртгэлээр хүлээлгэн өгч ашиглалтанд хяналт тавьж гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хохирсон иргэдийн лавлагааг тухай бүр авч мэдээллээр ханган ажилласан.

Хүнд гэмт хэрэг гарсан тухай бүрт албадын уялдаа холбоог хангаж Цагдаагийн газрын удирдлага болон тухайн өдрийн жижүүрийн прокурор, хэргийн газрын үзлэгийн багт мэдэгдэн түргэн шуурхай хойшлуулшгүй ажиллагааг зохион байгуулан, хэргийн газарт ажиллаж байгаа алба хаагчдыг цагдаагийн байгууллагын мэдээллийн санг ашиглан шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажилласнаар урьд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 170 иргэний мэдээллийг

хэргийн газрын үзлэгийн багийг удирдаж байгаа алба хаагчид мэдэгдэж ажилласан байна.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 234 дуудлага мэдээллийг гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл бүртгэх тусгай бүртгэлд хүлээн авч, хууль журмын дагуу хойшлуулшгүй ажиллагаа явуулж аюулын зэргийн үнэлгээг хийж тусламжийн хуудас өгч ажилласан. Аюулын зэргийн үнэлгээг тухай бүрт цаг алдалгүй хийж байгаа нь гэмт хэрэг, зөрчлийн материалыг шүүхийн шатанд шийдвэрлэх тохиолдолд шүүгч аюулын зэргийн үнэлгээг харгалзан үзэж шийдвэр гаргаж байна. Хариуцсан нутаг дэвсгэрээс 108 тусгай дугаарт хандсан 3 тохиолдол гарсныг хүлээн авч холбогдох албан тушаалтанд мэдэгдэн шийдвэрлүүлсэн.

Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс болон тухайн газар, хэлтсийн жижүүрийн ахлах мөрдөгч нар “Од програм” дээр хэрхэн ажиллах талаар хариуцсан алба хаагч нарт сургалтыг нийт 10 удаа зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас шуурхай удирдлагын хэлтэс, тасгуудаас хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа тодорхой үр дүнгээ өгсөн шинэлэг ажил, тэргүүн туршлага гарын авлагад тус Цагдаагийн газрын шуурхай удирдлагын тасгийн шинээр санаачлан зохион байгуулсан хоёр ажил тусгагдсан. Үүнд:

1.Сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргалгүй үр дүнтэй ажиллаж байгаа алба хаагчдын гэр бүлд “ТАЛАРХАЛ” хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

2.Цагдаагийн газрын нийт алба хаагчдын сэтгэл зүйн түвшинг тодорхойлж, дүгнэлт гарган аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдад чиглэсэн ажил, арга хэмжээг санаачлан зохион байгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд цагдаагийн байгууллагад дуудлага мэдээлэл өгөхдөө цагдаагийн газрын 94447102 тоот дугаарын утас руу мессежээр Сүхбаатар суманд үйлдэгдсэн бол товчлол нь СБ зай аваад 1 гээд хаягаа бичнэ. 1-ийн тоо нь гэмт хэрэг зөрчлийн дуудлага мэдээлэл гарсан гэсэн утгийг агуулах талаар зөвлөгөө өгч ажилласан.

Шинээр байршил тогтоогч “GPS” төхөөрөмжийг жижүүрийн албанд бэлэн байдалд байлгаж алсын дуудлага мэдээлэлд явж байгаа хэргийн газрын үзлэгийн баг, албан ажлаар явж байгаа алба хаагч нар ашиглаж байна.

“Орон нутгийн зам хөдөлгөөний соёл”, “Нуугдмал” “Цахим Тоглоом”, “Автомашин-2019”, “Байгалиа хамгаалья”, “Залилах”, “Яараад яахав дээ” “Улсын дугаар-2019”, “Нэг хором”, “Зөв тусгал”, “Сэрэмжлүүлэг” “Зэвсэг”, “Илрүүлэлт-Оргодол Шийдвэрлэлт” зэрэг нэгдсэн болон тусгай арга хэмжээ аяны хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2340 хүнд яриа таниулга хийж, алба хаагч нараас нуугдмал галт зэвсгийн талаар “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” /код-307/-д заасны дагуу мэдээ мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж 23 мэдээллийг “E-moirs” санд шивж оруулан эрүүгийн цагдаагийн тасагт илтгэх хуудсаар танилцуулж ажилласан.

Тасгийн алба хаагчид шүүхээс даалгасан бусад хүнээр эрэн сурвалжлагдаж байсан 16 иргэнийг олж тогтоон хариуцсан алба хаагчид илтгэх хуудсаар танилцуулж ажилласан.

Мөрдөн байцаах албанаас зохион байгуулж байгаа “Ятгах тусам нягтал” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд тасгийн алба хаагчид хариуцсан 21 аж ахуйн нэгж, албан байгууллагын ажилтан алба хаагч нарт сургалт зохион байгуулж, шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 21 албан мэдэгдэл өгч ажиллаа.

Гэмт хэргийн санд бүрдүүлсэн маягт 5758, үүнд тасгийн дарга нарын хянасан маягт 2380, мэдээлэл, судалгааны мэргэжилтэн нарын хянасан маягт 3378, зөрчлийн санд бүрдүүлсэн маягт /3110, 3112, 3113 маягт/ 4635, үүнд

мэдээлэл судалгааны мэргэжилтэн, зөрчлийн тоо бүртгэгч нарын хянасан маягт 4635 байна.

Нийт бичигдсэн 10393 мэдээллийг нягтлан шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт нь буцаан алба хаагчдаар засуулж ажилласан байна.

Гэмт хэрэг, зөрчлийн талаар холбогдох судалгааг тасаг албадын дарга, алба хаагчдад тухай бүрт нь гарган өгч ажиллаа.

Цагдаагийн байгууллагын нэгдсэн сангийн ял шийтгэгдсэн эсэх тодорхойлолт авах хүсэлтийн дагуу сангаас 920 иргэний лавлагааг гаргаж хариуцсан байцаагч нарт нь хүлээлгэн өгөв.

Мөн бусад цагдаагийн газар, хэлтсээс ирүүлсэн 31 албан бичгийн дагуу 67 иргэний мэдээ мэдээллийг сангаас шүүж хариуг өгч ажиллалаа.

2.8. Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны талаар: Тус Цагдаагийн хэлтэс нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газар, Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан 7 бүлэг 59 заалттай салбар төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлт 81,4 хувьтай байна.

Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах журам /код-113/-ыг хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн хэлтсийн алба хаагчдад мэдээллийн болон албаны тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах, албаны баримт бичгийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр хичээл сургалт зохион байгуулж, алба хаагчдад зөвлөмж өгсөн.

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах, Цагдаагийн хэлтсийн 2018 оны үйл ажиллагааны тайланг иргэдэд хүргэх, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилах, иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, санал хүсэлтийг нь хүлээн авах ажлыг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж иргэдэд тайланг танилцуулж, тэднээс 12 төрлийн санал хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэв.

Алба хаагчдын ажлыг сар бүр дүгнэж ажлын үр дүн хангалттай дүгнэгдсэн /давхардсан тоогоор/ 278 алба хаагчийн цалинг 5-20 хүртэл хувиар нэмэгдүүлж, ажлын үр дүн хангалтгүй, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлээгүй, прокурорын шаардлага болон албан бичгээр зөрчил заагдсан /давхардсан тоогоор/ 331 алба хаагчийн цалинг 5-20 хувиар бууруулж хэлбэлзэлтэй олгосон байна. Цагдаагийн хэлтсийн удирдлагад иргэдээс ирүүлсэн 6 гомдол мэдээллийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэв.

Энэ онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр “Сар шинэ-2019”, “Нэг хором”, “Залилах гэмт хэргийн оргодол шийдвэрлэлт 2019”, “Нуугдмал”, “Гадна талын гэрэлтүүлэг хэрэгсэл”, “Автомашин-2019”, “Бяцхан зорчигч”, “Байгалиа хамгаалья”, “Мотоцикл”, “Бодис-2019”, “Залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Ачааны автомашин-2019”, “Яараад яахав дээ”, “Зөв тусгал”, “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл-2019”, “Улсын дугаар 2019”, “Дураараа бишээ дүрмээрээ”, “Эко 2019”, “Хичээлийн шинэ жил”, “Тэсрэх бодис 2019”, “Мөнгө угаах”, “Судалгаа хяналтын сан”, “Илрүүлэлт оргодол шийдвэрлэлт”, “Зэвсэг-2019”, “Ойлгоё хүндэлье”, “Шийдвэрлэлт-2”, “Хулгай-2019”, “Цахим тоглоом-1”, “Хяналт”, “Цахим тоглоом-2”, “Хяналт-1, 2”, “Сэрэмжлүүлэг”, “Мал хяналт”, “Захирамж”, “Хар тамхи”, “Судалгаа” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ 27, олон нийтийн ухуулга, нөлөөллийн 4 аяныг зохион байгуулж, үр дүнг тухай бүр тооцон ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсгийн байцаагч, багийн цагдаа нар Мандал сумын 1, 6, 2, 9, 3, 7 дугаар багт оршин суудаг 180 айл өрхөөр

зочилж 630 хүнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор энэ оны 04 дүгээр сарын 08, 10 дугаар сарын 09-ны өдөр “Соёмбот” талбай дээр Мандал суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр иргэдийн хууль эрх, зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, тэдэнд хууль зүйн зөвлөгөө өгөх, гаргасан санал, хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх зорилгоор Мандал суманд үйл ажиллагаа явуулдаг хуулийн байгууллагуудын хамтарсан өдөрлөгт оролцож, 3 иргэнээс гаргасан саналыг хүлээн авч, өдөрлөгт оролцсон иргэдэд 8 төрлийн 250 ширхэг санамж, сэрэмжлүүлгийг тарааж ажилласан.

Гэмт хэргийн илрүүлэлтийн талаар: Хариуцсан нутаг дэвсгэрт 2019 оны 11 дүгээр сарын байдлаар бүртгэгдэх үедээ сэжигтэнээр татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 169 гэмт хэрэг бүртгэгдсэний 117 буюу 69.2 хувийг нь илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэргийн илрүүлэлт 22.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эрүүгийн цагдаагийн хэсгийн алба хаагчдаас 185 холбогдогчтой, 764.951.000 төгрөгийн хохиролтой 175 хэрэг, үйлдлийг илрүүлэн шалгаж хэрэг бүртгэлтийн хэрэг нээн эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулах саналтай мөрдөн байцаах хэсэг болон харъяа цагдаагийн газар, хэлтсүүдэд шилжүүлэн ажилласан байна.

Эрэн сурвалжлах ажлын талаар: Цагдаагийн хэлтсээс эрэн сурвалжлах “ASAP” санд 8 төрлөөр 149 эрэн сурвалжлалт зарлан мэдээллэж ажилласнаас гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 32, сураггүй алга болсон 15, мал амьтан 5, эд зүйл 34, оргодол 5, тээврийн хэрэгсэл 8, шүүхээс даалгасан 31-г тус тус эрэн сурвалжлалт зарлаж, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Энэ оны 11 дүгээр сарын байдлаар эрэн сурвалжлах “ASAP” санд тус хэлтсээс зарлан мэдээлсэн гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 42, эд зүйл 15, тээврийн хэрэгсэл 7, шүүхээс даалгасан хүн 45, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 1, сураггүй алга болсон хүн 15, мал амьтан 1, оргодол 6, галт зэвсэг 1-г тус тус олж тогтоон нийт 133 эрэн сурвалжлалтыг зогсоосон байна. Эрэн сурвалжлах ажлын үр дүн 89.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мөрдөн байцаах чиглэлээр: Мөрдөн байцаалтанд иргэд, байгууллага аж ахуйн нэгжээс гэмт хэргийн шинжтэй 116 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаж, үүнээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, эрүүгийн хэрэг үүсгэсэн 87, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 25, харъяаллаар бусад газарт шилжүүлсэн 4, одоо үлдэгдэлгүй байна.

Хэсгийн хэмжээнд мөрдөн шалгах ажиллагаанд 185 холбогдогчтой 218 хэрэгт хэрэг бүртгэлт, эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж шалгасан ба үүнээс 114 холбогдогчтой 145 хэргийг шүүхэд шилжүүлж, хэрэг бүртгэлтийн 31 хэргийг хаах буюу хэрэгсэхгүй болгох саналтай, 6 хэргийг бусад газарт харъяаллын дагуу шилжүүлж, 1 хэргийг нэгтгэж, 1 хэргийг түдгэлзүүлсэн ба хэргийг шийдвэрлэлт 184 хэрэг буюу 84.4 хувьтай, үлдэгдэл 34 хэрэг бүртгэлт, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны хэрэг бүртгэлтийн 12 хэрэгт 1-2 дугаар хугацаа сунгаж, шүүхээс 2 хэрэг, прокуророос 6 хэрэг буцаж 5 хэргийг шийдвэрлээд байна.

Иргэд аж ахуйн нэгж, байгууллагад гэмт хэргийн улмаас 249.192.000 сая төгрөгний хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 245.750.000 сая төгрөгний хохиролыг нөхөн төлүүлсэн нь 98.6 хувьтай байгаа ба иргэний нэхэмжлэл, эд хөрөнгө хураах байдлыг хангах зорилгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшлийн 128.206.105 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн байна.

Мөрдөн шалгах ажиллагааны оролцогчдоос 19 хүсэлт ирүүлснийг хүлээн авч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хүсэлтийг авч 15 хангаж, 1 татгалзаж, 3 хэсэгчилэн хагасан байна.

Мөрдөн шалгах ажиллагааг харъяаллын бус мөрдөн шалгах байгууллагаар хийлгэхээр мөрдөгчийн санал 11 хүргүүлж хариуг авч мөн бусад газраас энэ чиглэлээр ирүүлсэн 55 даалгаварыг хүлээн авч заасан хугацаанд нь ажиллагааг хийж хүргүүлэн, одоо 1 даалгаварын үлдэгдэлтэй байна.

Хэсгийн даргаас алба хаагч нарт үйл ажиллагааны чиглэлээр 6, хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр 17 “Даргын даалгавар” бичиж алба хаагч нарт хүргүүлсэн, ахлахаас мөрдөгчөөс мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэрэг бүртгэлт, эрүүгийн хэрэгтэй танилцаж, 6 зааварчилгааг бичгээр өгч ажилласан.

Цагдаагийн хэлтсийн орон тооны бус “Мэргэжлийн зөвлөл”-өөр хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны явцад прокурор, шүүхээс буцсан, хугацаа сунгасан, түдгэлзүүлсэн, ээдрээ төвөгтэй, шийдвэрлэгдэхгүй удаж байгаа 2 хэргийг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Энэ онд “Эд мөрийн баримт хадгалах өрөө”-нд 14 хэргийн 24 ширхэг эд мөрийн баримт хадгалж, хадгалахтай холбоотойгоор санал, гомдол гараагүй ба прокурорын хуваарьт хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй, бүрэн бүтэн журмын дагуу хадгалагдаж байна.

Хэрэг бүртгэх чиглэлээр: 2019 оны байдлаар иргэд, аж ахуй, нэгж байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 42 гомдол мэдээлэл хүлээн авч 37 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг, эрүүгийн хэрэг үүсгэн, бусад газарт харъяаллын дагуу 1 шилжүүлэн, 4 хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж одоо үлдэгдэлгүй байна.

Хэрэг бүртгэлтийн ажиллагаанд 36 холбогдогчтой 36 хэрэгт хэрэг бүртгэлт, эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж, 27 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлж, 5 хэргийг хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, харъяаллын дагуу 3 хэргийг шилжүүлж одоо 1 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагчдаас эрүүгийн 79 хэрэг шалгаж, 69 хэргийг шүүхэд шилжүүлж, 4 хэргийг нэгтгэж, 3 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай шилжүүлж, 2 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж одоо ажиллагаанд 1 хэргийн үлдэгдэлтэй шалгаж байна.

Иргэд аж ахуй нэгж, байгууллагад 27.508.960 сая төгрөгний хохирол учирснаас 25.408.510 сая төгрөгний хохирол нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 92.4 хувьтай, битүүмжилсэн хөрөнгө байхгүй байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Мөрдөгчийн мэдэгдэл” 72-г бичиж холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэн 51-н мэдэгдлийн хариуг авч ажилласан

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар багийн иргэний 7 тооны гахайнаас гоц халдварт “Гахайн Африк мялзан” өвчний шинж тэмдэг илэрсэн тул Сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/10 тоот “Гахайн Африк мялзан” өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах тухай”, мөн оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/13 тоот “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хэлтсийн Гамшигийн үед ажиллах төлөвлөгөө, хуваарьт тодотгол хийж, Мандал сумын Хэрх тосгоны Холбоо толгой, Хараа голын гүүр, Төмөр замын гарам зэрэг 3 цэгт 24 цагийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн хяналтын цэгийг байршуулан, цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, мэргэжлийн хяналтын албадын алба хаагчдыг хуваарийн дагуу томилон ажиллуулсан.

Энэ хугацаанд хяналтын 3 цэгт давхардсан тоогоор цагдаагийн 45 алба хаагч, 1448 хүн/цагийн, эргүүл шалгалтанд 12 удаа давхардсан тоогоор 68 алба хаагч 514 хүн/цагийн үүрэг гүйцэтгэн ажилласан. Хяналтын цэгээр дамжин өнгөрсөн нийт 11412 тээврийн хэрэгслийг шалгаж ариутгалд хамруулж, замын хөдөлгөөнд оролцох үедээ зөрчил гаргасан 94 жолоочид 3.835.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч хариуцлага тооцов.

Засаг даргын захирамжаар байгуулагдсан устгалын ажлын хэсэгт 1 алба хаагч томилон ажиллуулав. Энэ хугацаанд 22 өрхийн 572 тооны гахай, 243 тооны золбин нохой устгалд оруулсан байна. Мандал сумын хэмжээнд гахайн аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх, ам бүл, гахайн тоо болон дээрх айл, өрхийн эзэмшилд байгаа тээврийн хэрэгслүүдийн судалгааг гарган холбогдох мэргэжлийн байгууллага, алба хаагчидтай хамтран гахайн мялзан өвчин илэрсэн айл өрхийн гахайг устгах, ариутгал халдваргүйжүүлэлтэд хамруулах ажлыг зохион байгуулав.

Замын цагдаагийн ажлын чиглэлээр: Хэлтэс болон хэсгийн 1, 2 дугаар улирлын төлөвлөгөөнд тусгагдсан заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мандал сумын аж ахуйн нэгж байгууллагуудын дарга, эрхлэгч нарыг оролцуулсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, учирч буй хүндрэл бэрхшээлийг бууруулах нь” сэдэвт онол практикийн бага хурлыг Засаг даргын тамгийн газрын иргэний танхимд зохион байгуулав. Онол, практикийн бага хуралд 25 аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нар оролцож, хүндрэл, бэрхшээлийг тодорхойлов.

Улаанбаатараас Дархан-Уул аймгийн орон нутгийн чанартай авто замд, зам засварын ажил хийх зорилгоор урьдчилсан байдлаар нөөц замын судалгааг гаргахаар тоимлогдсон ажлын хэсэг 125 дахь км-ээс Хустайн даваа хоорондох 57.5 километр замын нөөц замын судалгааг гаргахад хамтран ажиллав.

Гудамж, замд хяналт шалгалтаар нийт 12627 тээврийн хэрэгсэл шалгаж зөрчил илрүүлж 10224 иргэнийг 253,029,000 төгрөгөөр торгох арга хэмжээ оногдуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 453 иргэнийг илрүүлж үүнээс Зөрчлийн тухай хуулийн 14.7 зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар 340 иргэний жолоодох эрхийг 1 жилийн хугацаатайгаар хасч, 89,600,000 төгрөгөөр торгож, шүүгчийн шийдвэрээр 113 иргэнийг 7-14 хоногийн хугацаатайгаар баривчлуулав. Зөрчлийн тухай хуулийн 14.7 зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 85 иргэнийг 12,600,000 төгрөгөөр торгож, 1824 иргэний зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан.

Санхүү, аж ахуй, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар: 2019 оны 11 дүгээр сарын байдлаар санхүүжилт төлөвлөгөөгөөр 1.226.233.800 төгрөг, гүйцэтгэлээр 1.226.233.800 төгрөг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 11.000,000 төгрөг, гүйцэтгэлээр 5.869,900 төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 5.130,100 төгрөгөөр биелээгүй байна. Энэ нь тээврийн хэрэгсэл саатуулах байрыг сумын мэдэлд шилжүүлсэнтэй холбоотой болно.

Гэрэл цахилгаан 2.107.508 мянган төгрөгний хэтрэлттэй байна. Төсвийг зүй зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх тал дээр анхааран харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэн ажиллаж байна. 2020 оны төсвийн төсөл 2021-2022 оны төсвийн төсөөллийг ЦЕГ-ын СААА-нд хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаа. Хоолны зардал, гэрэл цахилгааны зардлыг нэмэгдүүлэхээр төсөвт тусгуулан ажилласан. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийг тогтоосон нийтлэг стандартын хүрээнд маягт, зааварын дагуу цаг хугацаанд нь шилэн дансны нэгдсэн систем болон өөрийн байгууллагын Mandal police sov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.

2.9. Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлээр: Цагдаагийн хэлтсийн удирдлага, зохион байгуулалтын арга, хэлбэрийг

сайжруулах, хуулиар хүлээсэн чиг үүргийг биелүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас 2019 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан тус онд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 бүлэг, 57 заалттайгаар боловсруулан баталж, хэсэг, албадад хүргүүлэн, хэрэгжилтийг хангах ажлуудыг зохион байгуулав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 95.6 хувьтай хэрэгжүүлээ.

Тус хэлтсээс энэ онд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх болон бусад ажлын чиглэлээр хэсэг, албадууд 70 төрлийн 723 заалттай төлөвлөгөө, удирдамжийг боловсруулж, холбогдох ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллав.

Цагдаагийн байгууллагын хуульд заасан чиг үүргийн хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газраас биелэлт, үр дүнг нь тооцож хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр 114 бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэхээр хүлээн авч, хэрэгжилтийг хангах ажлуудыг зохион байгуулан, тогтоосон хугацаанд биелэлтийг хүргүүлэв.

Тус хэлтсээс цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/37 дугаартай тушаалаар баталсан “Зөв хэвшил, хандлага I, II” аяны хүрээнд алба хаагчдын ажлын үр дүнг, албандаа хандах хандлагыг сайжруулах чиглэлээр 11, цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 3/74 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх” хөтөлбөр, ажил, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах зорилгоор 8, цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/120 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр 19, мөн газрын даргын 2018 оны А/135 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл цагдаа хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр 11, нийт 47 ажил, арга хэмжээг зохион байгуулан үр дүнг тооцож ажилласан.

Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-нд нийцүүлэн алба хаагчдын дунд зохион байгуулах соён гэгээрүүлэх ажлын 4 зорилт, 32 заалт бүхий салбар төлөвлөгөөг боловсруулан, энэ оны 02 дугаар сарын 03-ны өдөр хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу тус хэлтсээс 2019-2021 онд хэрэгжүүлэх салбар ажлын төлөвлөгөөг боловсруулан батлав. Тус хөтөлбөрийн хүрээнд ахмад, дунд, залуу үеийн харилцааг бэхжүүлэх, мэргэжлийн ёс зүй, албанд хандах хандлага дээшлүүлэх зорилгоор 8 ажил, арга хэмжээг зохион байгууллаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/120 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр 2019 онд тус хэлтсээс “Ногоон тууз”, “Алба хаагчдын нэрэмжит өдөрлөг”, “Талархлын өдөр”, “Бичил номын сан”, “Урлагийн бага наадам”, “Dance police” цэнгээнт бүжгийн дугуйлан, “Ажлын байрны стрессийг бууруулах нь” сэдэвт өдөрлөг, “Инээмсэглэх өдөр”, “Харилцаа ба хандлага”, “Хамт олны уур амьсгал” сэдэвт өдөрлөг, сургалт, танин мэдэхүйн 11 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцов.

Тус цагдаагийн хэлтсээс гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах ажилд орчин үеийн техник, технологийн ололттой талыг ашиглах зорилгоор Сайхан, Орхон, сумдын ГХУСАЗСЗ болон Засаг дарга нарт техник, хэрэгслийн хэрэгцээ, шаардлагын талаар холбогдох судалгаа, баримтад тулгуурлан танилцуулга бичиж хүргүүлэв. Бичсэн танилцуулга, холбогдох саналын хүрээнд Сайхан сумын Засаг даргаас 15.000.000 төгрөгийн өртөгт багтаан хурд хэмжигч багаж худалдан авах санхүүжилтийг шийдвэрлэв. Орхон сумын Засаг даргаас 3.000.000 төгрөгийн өртөг бүхий агаарын “дрон” төхөөрөмжийг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор шийдвэрлэж өгөв.

Сум дундын Шүүх, Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэгтэй хамтран “Хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн уулзалт, зөвлөгөөн”-ийг энэ оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулав. Зөвлөгөөний үеэр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал”, “Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа”, “Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа” сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг явуулав. Зөвлөгөөнд сумын хууль, хяналтын байгууллагын 48 ажилтан, алба хаагчид хамрагдав.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Цагдаагийн байгууллагын 2019 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр баталсан “Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын 2019 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”-нд уялдуулан хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажлын салбар төлөвлөгөөг 4 бүлэг 36 заалттайгаар боловсруулан батлав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулах зорилгоор хариуцсан нутаг дэвсгэртээ “Сар шинэ-2019”, “Тусгай дуут дохио”, “Нэг хором”, “Хурд”, “Цонх ба хаалга”, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал”, “Залилах гэмт хэргийн шийдвэрлэлт”, Оргодол”, “Ачааны машин-ачаа тээвэрлэлт”, “Мотоцикль”, “Автомашин-2019”, “Зөв тусгал”, “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл”, “Бяцхан зорчигч”, “Байгалиа хамгаалъя”, “Бодис”, “Бүртгэл-2019”, “Мөнгө угаалт-хяналт”, “Яараад яахав дээ”, “Дураараа биш дүрмээрээ”, “Улсын дугаар”, “Мотоцикль-2”, “Хичээлийн шинэ жил-2019”, “Устгал-2019”, “Эко-2019”, “Судалгаа”, “Бумба-2019”, Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт, “Орц”, “Зэвсэг-2019”, “Хөрш амгалан бол бид амгалан”, “ОйлГОЁ ХҮНдэлье” зэрэг 31 төрлийн нэгдсэн ба хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, үр дүнг тооцов.

Мөрдөн байцаах албаны чиглэлээр: Тус хэсгээс хэргийн шийдвэрлэлтийг ахиулах зорилгоор “Сар шинэ-2019”, Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр “Залилах гэмт хэргийн шийдвэрлэлт”, оргон зайлсан этгээдийг олж тогтоох, илрүүлэх зорилгоор “Оргодол”, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр “Байгалиа хамгаалъя”, “Бодис” зэрэг нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцов.

Тайлангийн хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй нийт 93 гомдол хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс 15 буюу 19.2 хувиар өсчээ. Үүнээс 62 гомдол мэдээлэл буюу 66.6 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, ... гомдол мэдээлэл буюу .. хувьд нь шууд эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 21 гомдол мэдээлэл буюу 22.5 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 3 гомдол мэдээлэл буюу 3.2 хувийг харъяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэв. Нийт шалгасан гомдол мэдээллийг шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Мөрдөн байцаалтын 91 холбогдогчтой 78 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 84.6 хувь буюу 80 холбогдогчтой 66 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорын хяналтанд шилжүүлж, 8.9 хувь буюу 7 хэргийг нэгтгэж, 6.5 хувь буюу 5 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлжээ. Одоо ажиллагаанд мөрдөн байцаалтын 4 холбогдогчтой 4 хэргийн үлдэгдэлтэй байгаа ба хэргийн шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Хэрэг бүртгэлтийн 82 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж 34 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах саналтай, 43 хэргийг хаах саналтай, 6 хэргийг харьяаллын дагуу бусад газарт шилжүүлэх саналтайгаар хяналтын прокурорт хүргүүлж шийдвэрлэв. Ажиллагаанд хэрэг бүртгэлтийн 6 хэргийн үлдэгдэлтэй байгаа ба хэргийн шийдвэрлэлт 93.2 хувьтай байна. Нийт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 133 хэрэгт шалгах болон түүвэр төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллав. Гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй 19 яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүллээ.

Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуй нэгж, албан байгууллагад 433.950.092 төгрөгийн хохирол учирснаас 65.5 хувь буюу 284.371.520 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Тайлангийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 430 гомдол мэдээллийг хүлээн авчээ. Үүнээс 211 гомдол мэдээлэл буюу 49 хувийг гэмт хэргийн шинжтэй, 219 гомдол мэдээлэл буюу 51 хувийг захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл тус тус эзэлж байна.

Шалгасан 430 гомдол мэдээллийг урьд оны мөн үетэй /487/ харьцуулахад 57 буюу 11.7 хувиар буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 41 буюу 23.7 хувь өссөн байх ба захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 98 буюу 31.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийг урьд оны мөн үетэй харьцуулбал : Шийтгэлийн хуудсаар торгосон 55 буюу 41.3 хувиар буурсан бол захиргааны журмаар баривчилсан хүн 22 буюу 39.3 хувиар, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах шийтгэл 10 буюу 10 хувиар тус тус өссөн дүнтэй гарчээ.

Энэ оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Сэлэнгэ аймгийн Орхон сумын 3 дугаар баг төмөр замын 42 дугаар зөрлөг буюу “Бэлэн далай” баг, Сант сумын 1 дүгээр баг Номуунхааны 1-1 тоот хаягт “Африкийн гахайн мялзан” нэршилтэй малын гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн ба улсын мал эмнэлэг ариун цэвэрийн төв лабораторийн тасгийн дарга, шинжлэгч эмч, техникийн менежер нарын 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн №19/348, 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн №19/453 дугаартай шинжилгээгээр “Африкийн гахайн мялзан” өвчин болох нь тогтоогдсон бөгөөд тус хэлтсээс “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг үндэслэн хорио цээрийн дэглэмд хэв журам сахиулах зорилгоор батлагдсан төлөвлөгөө, зураглалын дагуу /давхардсан тоогоор/ 8 алба хаагч Онцгой байдлын албаны 12, мал эмнэлэгийн 4 ажилтантай хамтран, халдварт өвчний голомтод 45 хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэн ажиллав. Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд гоц халдварт өвчнөөр 81 тооны гахай өвчилснөөс 78 гахайг устгалд оруулжээ.

Замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтын чиглэлээр: Зам тээврийн 213 гомдол мэдээлэл бүртгэгдэн шалгагдсан. Үүнээс гэмт хэрэг 15, осол 24 бүртгэгджээ. Үйлдэгдсэн осол, гэмт хэргийг өнгөрсөн онтой харьцуулан үзвэл 11 буюу 42.3 хувиар буурсан дүнтэй байна. Осол, гэмт хэргийн улмаас 9 хүн нас барж, 13 хүн гэмтэж хохирчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал осол, гэмт хэргийн улмаас нас баралт 25 хувиар өсч, гэмтэж бэртсэн хүний тоо 23.5 хувиар буурсан дүнтэй байна.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, осол хэргийн гаралт, үүнээс үүдэлтэй нас баралт, гэмтлийг багасгах, замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр “Сар шинэ-2019”, “Аюулгүй тээвэр”, “Осол, гэмтлээс сэргийлье”, “Мотоцикль”, “Ачааны автомашин-ачаа тээвэрлэлт”, “Тусгай дуут гэрэл дохио”, “Хурд”, “Бяцхан зорчигч”, Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл”, “Яараад яахав дээ”, “Дураараа биш дүрмээрээ” зэрэг нэгдсэн ба хэсэгчилсэн арга хэмжээ, ухуулга нөлөөллийн аяны хүрээнд орон нутгийн замд гарч болзошгүй осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, осол хэргийн гаралт, үүнээс үүдэлтэй нас баралт, гэмтлийг багасгах, замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж, үр дүнг нь тооцов.

Мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлагын чиглэлээр: Иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас нийт 444 дуудлага, мэдээллийг хүлээн авч бүртгэн, холбогдох хэсэг, тасгийн албан тушаалтанд дамжуулсан.

Гэмт хэргийн шинжтэй 226, зөрчлийн 218 дуудлага мэдээллийн талаар хэлтсийн удирдлагад танилцуулан хойшлуулшгүй ажиллагааг явуулав. Гэмт хэргийн дуудлага, мэдээллийг өнгөөр нь авч үзвэл : Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 55, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 22, золгүй байдлаар нас барсан 40, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 17, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн 17, залилах гэмт хэргийн 16, хөрөнгө завших гэмт хэргийн 3, шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 5, бэлгийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн 28, хүүхдийн эсрэг гэмт хэргийн 1, бусад 21 буюу нийт 226 гэмт хэргийн шинжтэй дуудлага мэдээлэл бүртгэгдсэн.

Зөрчлийг өнгөөр нь авч үзвэл: зам тээврийн осол 24, хэв журмын зөрчил 80, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 66, оршин суугаа газраасаа алга болсон 3, бусад 45 дуудлага мэдээлэл тус тус бүртгэгджээ.

Цагдаагийн байгууллагад иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн дуудлага, мэдээллийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 46 буюу 9.4 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Зохион байгуулсан спорт, соёл урлагийн арга хэмжээний талаар: Биеийн тамир, спортын арга хэмжээг бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулах ажлыг хэвшүүлэх, алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тус хэлтсээс 17 төрлийн соёл урлагийн болон спортын тэмцээн уралдааныг зохион байгуулж, /давхардсан тоогоор/ 595 тамирчин, алба хаагчид оролцлоо.

3.1.Бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар: Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэд аж ахуйн нэгж, байгууллагаас энэ онд нийт 444 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаж шийдвэрлэв. Үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 226 буюу 51 хувь, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 218 буюу 49 хувийг тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гомдол мэдээллийг урьд оны мөн үетэй харьцуулбал 46 гомдол мэдээлэл буюу 9,4 хувиар буурсан, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 48 буюу 27 хувиар өссөн, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 94 буюу 30.1 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Гэмт хэргийн шинжтэй 226 гомдол мэдээллийн 157 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 66 гомдол мэдээллийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр татгалзаж, 2 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн ба одоо ажиллагаанд 1 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өнгөөр нь авч үзвэл: хүнийг алах гэмт хэрэг 3, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 21, хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 24, бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7, хулгайлах гэмт хэрэг 19, мал хулгайлах гэмт хэрэг 27, дээрэмдэх гэмт хэрэг 3,

залилах гэмт хэрэг 7, хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг 1, хууль бусаар ан агнах гэмт хэрэг 1, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 8, байгалийн ургамлыг хууль бус бэлтгэх 2, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 1, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 15, бусад төрлийн гэмт хэрэг 18 тус тус бүртгэгдэн шалгагдсан.

Шалгасан 444 гомдол мэдээллийг 100 хувь хуулийн анхны хугацаанд нь шийдвэрлэлээ.

Зөрчлийн шинжтэй 218 гомдол мэдээллийн 95 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээн шалгасан ба 83 гомдол мэдээллийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзаж, 37 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчилд холбогдсон 4617 иргэнийг 150.005.500 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч, үүнээс 83 иргэнийг 11.230.000 төгрөгийн шийтгэвэрээр торгож, тусгайлан олгосон эрх хасах зөрчлөөр 112 иргэнд 44.800.000 төгрөгийн торгууль оногдуулсан ба нийт 4812 иргэнийг 206.035.500 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн байна.

Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний чиглэлээр: Энэ онд тус хэлтэс нь 771.171.500 т^оа^до^аийн төсвийн санхүүжилт авснаас а^зэ^оу^до^ау^ёийн о^до^аа^е н^ай^д з^аа^аа^аийг 100 о^оо^аиар гүйцэтгэсэн ба үндсэн үйл ажиллагааны орлогод 2.889.500 о^оа^до^аийг төсөвт төвлөрүүлжээ. Т^он^аа^е харилцахаар нийт 248 удаа буюу 730.660.323 о^оа^до^аийн а^зэ^оу^до^ау^ё о^ое^оо^ау^а 43.400.727 о^оа^до^аийн з^эа^уа^ау^ёо^уэ гарчээ. Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж, ахуйн албанаас 26.162 ширхэг шийтгэлийн хуудсыг авч, орлогод тусган албан хэрэгцээнд ашигласан.

Т^аэ^эа^агийн хугацаанд давхардсан тоогоор 92 а^эа^а о^оа^а+о^оа^э шийтгэлийн хуудасны о^оо^оо^ог хийж дуугасан ба 13.570.000 төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн. Хэлтсийн алба хаагчдын албан хэрэгцээнд зориулан о^ое^оо^оу^ле^э 329 о^оо^оа^ан и^эа^асон ба одоо 45.551 ширхэг шийтгэлийн хуудасын үлдэгдэлтэй байна. Хэлтсийн тухайн жилийн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын www.khutul.police.gov.mn цахим хуудас, шилэн дансны Shilendans.gov.mn/ нэгдсэн систем болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлж, төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангаж ажиллалаа.

Үйлчилгээний хөлс, төлбөр, хураамж болон байгууллагын орлогыг бүрдүүлэхдээ зохих хууль тогтоомжид заасан төлбөрийг үйлчлүүлэгчээс авч, төсвийн орлогыг бүрдүүлэн ажиллаж байгаа ба энэ талаар цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан.

Цагдаагийн хэлтсээс 2019 онд алба хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, орчны дотоод болон гадаад тохижилтыг дээшлүүлэх чиглэлээр жагсаалын талбайд гэрэлт самбар 2, хэлтсийн гадна хэсэгт иргэдэд мэдээлэл хүргэх чиглэлээр мэдээллийн самбар 1, цэцэрлэгт хүрээлэнгийн орчимд бичил цөөрөм 1, алба хаагчдын мэдлэг ур чадварыг сайжруулах ажлын хүрээнд дадлага, сургалт зохион байгуулах “Өгөөмөр” бичил цогцолбор 1, зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Сайхан сумын “Хөтөл хөшөө”-ний орчимд цахим дэлгэц бүхий “Гэрэлт хаалга” 1, хэлтсийн хурлын танхимын өргөтгөл засвар болон шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах чиглэлээр 1, нийт 7 ажил, арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

2.10.Цагдаагийн газарт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар:

Цагдаагийн газрын хэмжээнд 2019 оны эхний 11 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 3133 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1125 буюу

35,9 хувийг гэмт хэргийн шинжтэй, 2008 буюу 64,1 хувийг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл тус тус эзэлж байна.

Гэмт хэргийн шинжтэй 1125 гомдол, мэдээллийн 840-т нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 5-ыг харъяаллын дагуу шилжүүлж, 277-д нь хэрэг нээхээс татгалзсан саналыг прокурорт гаргаж, нийт бүртгэсэн гомдол мэдээллийн 1117 буюу 99,2 хувийг хуулийн хугацаанд нь шалган шийдвэрлэж, ажиллагаанд 3 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Зөрчлийн шинжтэй 2008 гомдол, мэдээллийн 921 гомдол мэдээллийг зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, 12 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 1057-д нь зөрчлийн шинжгүй татгалзах саналтай прокурорт хүргүүлж, 17 гомдлыг харъяаллын дагуу шилжүүлж, нийт бүртгэсэн гомдол, мэдээллийн 1993 буюу 99,2 хувийг хуулийн хугацаанд шалган шийдвэрлэж, ажиллагаанд 1 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авч бүртгэгдсэн 3133 гомдол, мэдээллийн 3110 буюу 99,2 хувийг хуулийн анхны хугацаанд шалгаж шийдвэрлэжээ.

Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 11 сард 527 холбогдогчтой 2121.6 сая төгрөгийн хохиролтой, 720 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 4 хэргээр буюу 0.5 хувиар буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 54,5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өссөн байна.

Хэрэг бүртгэлтийн 556 хэрэг бүртгэгдсэнээс эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар 303 хэрэг татаж, гэмт хэргийн илрүүлэлт 54,5 хувьтай байна.

Гэмт хэргийг үйлдэгдсэн байдлаар: : Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 85 бүртгэгдэж 38-аар буюу 80,8 хувиар, хүүхэд оролцсон гэмт хэрэг 37 бүртгэгдэж 13-аар буюу 54,1 хувиар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 93 бүртгэгдэж 5-аар буюу 5,6%-иар **өсч**,

- Гадаадын иргэн оролцсон гэмт хэрэг 2 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 2 **дахин**, гэр бүлийн хүчирхийллийн улмаас 39 гэмт хэрэг бүртгэгдэж 7-оор буюу 15,2%-иар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 161 бүртгэгдэж 7-оор буюу 4,1%-иар тус тус **буурсан** үзүүлэлттэй байна.

- Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 1, бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд байна.

Мансуурсан үедээ үйлдсэн гэмт хэрэг 3 бүртгэгдсэн.

Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 77 хүн холбогдож, 21-ээр буюу 33,6 хувиар **буурсан** байна.

Үйлдэгдсэн газраар: - Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 232 бүртгэгдэж 6-аар буюу 2,6%-иар **өсч**,

- Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 57 бүртгэгдэж 16-аар буюу 21,9 хувиар, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 50 бүртгэгдэж 18-аар буюу 26,4 хувиар, авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 45 бүртгэгдэж 18-аар буюу 28,5%-иар **буурсан** байна.

Хэргийн төрлөөр: -Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 36 бүртгэгдэж 17-оор буюу 1,8 дахин, үүнээс хүчиндэх гэмт хэрэг 26 бүртгэгдэж 12-аар буюу 1,8 **дахин**, дээрэмдэх гэмт хэрэг 13 бүртгэгдэж 7-оор буюу 2,1 дахин, хөрөнгө завших 26 бүртгэгдэж 18-аар буюу 3,2 дахин, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 6 бүртгэгдэж 3-аар буюу 2 **дахин өсч**,

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 310 бүртгэгдэж 57-аар буюу 22,5 хувиар, үүнээс хулгайлах гэмт хэрэг 149 бүртгэгдэж 11-ээр буюу 7,9 хувиар, хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 128 бүртгэгдэж 12-оор буюу 10,3 хувиар, гээгдэл эд зүйл, алдуул мал завших гэмт хэрэг 9 бүртгэгдэж 2-оор буюу 28,5 хувиар, автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах 5 бүртгэгдэж 1-ээр буюу 25,0 хувиар, мал хулгайлах 53 бүртгэгдэж 24-өөр буюу 82,7, авлигын эсрэг гэмт хэрэг 16 бүртгэгдэж

1-ээр буюу 6,6 хувиар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 101 бүртгэгдэж 18-аар буюу 21,6 хувиар, үүнээс хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 58 бүртгэгдэж 21-ээр буюу 56,7 **хувиар өсч,**

- Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг 19 бүртгэгдэж 10-аар буюу 34,4 хувиар, хүнийг алах гэмт хэрэг 8 бүртгэгдэж 1-ээр буюу 11,1 хувиар, хүний амь нас болгоомжгүй хохироох гэмт хэрэг 4 бүртгэгдэж, 2-оор буюу 33,3 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 169 бүртгэгдэж 67-оор буюу 28,3 хувиар, залилах гэмт хэрэг 48 бүртгэгдэж 5-аар буюу 9,4 хувиар, эд хөрөнгө устгах, гэмтээх гэмт хэрэг 5 бүртгэгдэж 2-оор буюу 28,5 хувиар, Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 5-аар буюу 83,3 хувиар, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг тус бүр 1 бүртгэгдэж 5-аар буюу 83,3 хувиар, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 6 бүртгэгдэж 3-аар буюу 33,3 хувиар, хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг 33 бүртгэгдэж 7-оор буюу 17,5 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 41 бүртгэгдэж 22-оор буюу 34,9 хувиар **буурч,**

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 5, хууль бусаар ан агнах гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна.

-Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг 4, халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 3, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 1 **бүртгэгдэж,** эрүүл мэндийн эсрэг, хүүхдийн эсрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, цэргийн албаны эсрэг, хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайваны эсрэг, бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх гэмт хэргүүд энэ онд **бүртгэгдээгүй.**

Гурав. Санхүү бүртгэл, аж ахуй, хангамж үйлчилгээний талаар:

Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад хууль эрхзүйн баримт бичгийг үндэслэл болгон төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулан, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, цагдаагийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, цагдаагийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, өр авлагагүй байх зорилтын хүрээнд ажиллалаа. 2018 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасны дагуу Аймгийн аудитын газарт хүргүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/156 дугаар тушаалаар итгэмжлэл авсан.

Төнийн хөрөнгийн үйл ажиллагаанд 1996782,8 иүйлээр төсвийн хөрөнгийн үйл ажиллагаанд 100 дотуудад байна. Төнийн хөрөнгийн үйл ажиллагаанд 17000,0 мянган төгрөг зарцуулж, төсвийн хөрөнгийн үйл ажиллагаанд 16850,0 иүйлээр төсвийн хөрөнгийн үйл ажиллагаанд 9980,1 мянган төсвийн хөрөнгийн үйл ажиллагаанд 6869,9 мянган төсвийн хөрөнгийн үйл ажиллагаанд тус тус оруулж. нэмэлт санхүүжилтийн 100130012401 тоот дансаар 70990,7 мянган төгрөг оруулсан байна.

Цалин хөлс, болон нэмэгдэл урамшил,ажиллагсадтай холбогдон гарсан зардалд 1793895,1 мянган төгрөгний гүйцэтгэлтэй

Байр ашиглалтын зардлын хувьд 45721,2 мянган төгрөг төсвийн дагуу зарцуулж, өглөг, авлагын тооцоогүй.

Бичиг хэрэг 11580, мянга, Тээвэр шатахуун 103978,8 мянга, шуудан холбоо 10073,7 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл 3300,0 мянга, эм бэлдмэл 1200,0 мянга, Хоол хүнсэнд давхардсан тоогоор 2976 алба хаагчид болон ЭББ-ны хүнс бүгд 19840,0 мянга, албан томилолтын зардалд давхардсан тоогоор 1340 алба хаагчид 15500,0 мянган төгрөг тус тус зарцуулан ажилласан байна.

Тайлант хугацаанд алба хаагчдын ажиллах нөхцөл болоцоог хангах ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалт батлагдсантай холбогдуулан 2019 онд цагдаагийн байгууллагын хэмжээнд шинээр баригдах Шаамар сумын Дулаанхаан тосгоны авто замын 4 замын уулзвар дээр замын хөдөлгөөний хяналтын байнгын пост барилгын гүйцэтгэлийг ажлын хэсгийн хамт хүлээн авч ашиглалтанд хүлээн авч данс бүртгэлд тусгасан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Авто баазаас олгогдсон туулах чадвар сайтай “ЗИЛ-131” маркийн автомашиныг явуулын пост, команд штабын зориулалтаар ашиглах зорилгоор тусгай техник, тоноглолоор тоноглож, 6 дугуй шинээр авч засвар үйлчилгээ хийн, орлогод авч ашиглалтанд оруулсан.

Шаамар сумын “Давгын дов” гэх газар цагдаагийн алба хаагчийн “Хээрийн дадлага сургалтын төв” шинээр байгуулан тохижилтын ажилд урсгал засварын зардлаас 8,2 сая төгрөгийг зарцуулсан.

Санхүүгийн сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийг үндэслэн 2020 оны төсөв, 2021-2022 оны төсвийн төсөөллийг заавар зөвлөмж, журмын дагуу гаргаж Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн. Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон цагдаагийн ахмад ажилтан болон алба хаагчдын тусламжтайгаар 104,0 сая төгрөгний үндсэн хөрөнгийг шинээр бий болгож төрийн өмчийн газраас зөвшөөрөл авч данс бүртгэлд бүртгэн ажилласан

Аймгийн Засаг даргын А/270 тоот захирамжийн хүрээнд хууль бусаар ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж, иргэдийг албадан нүүлгэх, үйл ажиллагааг нь таслан зогсоох ажлын хүрээнд байнгын пост ажлуулах зардалд Засийн газрын 341 дүгээр тогтоолоор 24,7 сая төгрөг олгогдож, шатахуун 12,7 сая, томилот 5,3 сая, хоол 3,9 сая төгрөг алба хаагчдад зарцуулсан.

Урсгал засварын зардлын хувьд цагдаагийн төв конторын үүд хэсэгт 7,5, эрүүлжүүлэх, саатуулах байрны ариун цэврийн өрөөний засварын материалд 3,8 сая, төгрөгийг хэмнэгдсэн ашиглалтын зардлаас бүлэг хооронд зардал шилжүүлэх саналыг Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын хавсралт маягтын дагуу гаргаж Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанд хүргүүлж шийдвэрлүүлсэн

Шилэн дансны системд шилэн дансны мэдээллийг улирлаар нь хуулийн хугацаанд нийтэлж, тухай бүрд мэдээлэх мэдээллийг хуулийн дагуу оруулж 5 сая-с дээш гүйлгээ бүрийг журмын дагуу нийтэлж ажилласан хэдий ч 12 дугаар сарын байдлаар Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс ажлын мэдээлэл зөвлөмж ирүүлсэний дагуу ажлын төлөвлөгөө гарган Мандал, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсүүдэд хүргүүлэн ажиллаж биелэлт, үр дүнг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанд хүргүүлээ.

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах журмын хүрээнд заагдсан биелэлт тус бүрийг үнэлж хүрүүлсэн бөгөөд хавсралт маяганд холбогдох санхүүгийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 05-ны дотор байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хавсралт маяганд мэдээлэл байршуулж, байгууллага дээрээ сар бүрийн мэдээ тайланг мэдээллийн самбарт байршуулан нийт бие бүрэлдэхүүнд танилцуулан шилэн дансны мэдээлэл байршуулж нийтэлсэн бүртгэл дэвтэр хөтлөн ажилласан. Үүнд 12 дугаар сарын байдлаар 102 мэдээлэл байршуулж мэдээлсэн байна.

Тухай бүр оруулах мэдээлэл хэсэгт 7 төрлийн мэдээллийг тухай бүр нь мэдээлж, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 4 гүйлгээний 28,890,984 төгрөгийн мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 60 гүйлгээний 130,058,480 төгрөгийн нийт 70 мэдээллийг байршуулж ажилласан.

Сар бүр оруулах мэдээлэл хэсэгт 2 төрлийн мэдээллийг сар бүр хугацаанд нь мэдээллэж нийт 20, улирал бүр оруулах мэдээлэл хэсэгт улирал бүрийн төсвийн

гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийг харуулан 3 дугаар улирлын мэдээллийг тус тус байршуулсан байна.

Алба хаагч, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр: Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж нийт 101 алба хаагч хамрагдсан.

Тус Цагдаагийн газраас 2019 онд эрүүл мэндийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 12 удаагийн 12 цагийн сургалтыг нийт алба хаагч нарт зохион байгуулж ажилласан.

Мөн “Номт” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтарч цагдаагийн газрын нийт алба хаагч нарыг нэгдсэн санд тулгалт хийж элэгийн вирус илрүүлэгийн шинжилгээнд хамрагдаагүй 28 алба хаагчийг элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулж, цаашид элэгний В вирусийн дархлаажуулалтын /1, 2, 3 тун/ вакцинжуулалтад хамрагдаагүй алба хаагч, ажилтны судалгааг эрүүл мэндийн төвөөс албан бичгээр авч, “Элэг бүтэн Монгол-2020” зорилтын хүрээнд вакцинжуулалтад алба хаагч, ажилтныг бүрэн хамруулах ажлыг зохион байгууллаа.

Алба хаагчдын өвчлөлийн судалгааг гаргаж, дээд шатны эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай 26 алба хаагчдыг эмчлүүлэх сувилуулах боломж нөхцлөөр хангасан.

Тус Цагдаагийн газрын Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 21 алба хаагчийг Холбооны Бүгд найрамдах Герман Улсын “Хил хязгааргүй шүдний эмч нар” Олон Улсын байгууллагын шүдний эмч нарын үзлэгт хамруулж, холбогдох эмчилгээг хийлгэсэн байна.

Батлагдсан төсвийн хүрээнд урсгал засварын 6,1 сая төгрөгийн зардлаар Цагдаагийн газрын хурлын танхимын ханыг засварлаж алба хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулан, алба хаагч, ахмад ажилтнууд, гэр бүлийн гишүүдийн амралт чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор амралтын газарт засвар үйлчилгээ хийлгэн ашиглалтанд оруулж, “Хээрийн дадлага сургалтын төв”-ийг шинээр байгууллаа.

Тус аймгийн Шаамар сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Дулаанхааны 4 замын уулзварт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар замын цагдаагийн хяналтын цэг, Сүхбаатар сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт шинээр замын цагдаагийн хяналтын цэгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн, Сайхан сумын Засаг даргын Тамгын газраас сумын замын цагдаагийн алба хаагч нарт хурд хэмжигч, согтуурал хэмжигч багаж авахад зориулж 15.0 сая төгрөгний хурд хэмжигч багаж төхөөрөмж авч өгсөнийг албан хэрэгцээндээ ашиглаж байна.

Сэлэнгэ аймгийн Орхон сумын Засаг даргын тамгын газарт төв суурин газарт эргүүл шалгалтад ашиглах зоригоор нисдэг хяналтын камер буюу “Дрон” авахуулах хүсэлт гаргасаны дагуу 2019 оны 03 дугаар сарын 13-нд “DJO” ХХК-иас “Majig zoom 2” маркын нисдэг хяналтын камерыг авахуулан алба хаагчид болон хөдөлгөөнт эргүүл шалгалт, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус Цагдаагийн газрын харъяа Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн удирдлагуудад албаны бэлтгэлийн танхим байгуулахад шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэх саналыг хүргүүлж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэн албаны

бэлтгэлийн танхимыг шинээр байгуулан 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр нээлтээ хийж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд тус аймгийн Ерөө, Хүдэр сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 3 алба хаагчийн гэр бүлд хувийн орон сууц барихад нь дэмжлэг үзүүлж, Аймгийн Засаг даргад хүсэлт хүргүүлэн 5 алба хаагчийг тус аймагт баригдаж буй төрийн алба хаагчдын орон сууцанд хөнгөлөлттэй нөхцлөөр хамруулах, Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн алба хаагчдад хөнгөлөлттэй үнээр 30 айлын орон сууц бариулах ажлыг эхлүүлээд байна.

Эх үрийн баярын тохиолдуулан алба хаагчдын "Алдарт эх"-ийн одонтой гэргий нарт хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулав.

Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсээс дотоод нөөц бололцоогоо ашиглан 2018 онд 2 га газарт хүнсний ногоог тарьж хураан авч, борлуулан 10.000.000 төгрөгөөр "DELL" маркын 10 ширхэг компьютер худалдан авч, алба хаагчдад хуваарилан өгч ашиглуулж байна, 2019 онд "Дарьт дахь хорих 433 дугаар" ангитай гэрээ байгуулан 3 га газарт хүнсний ногоо тариалсан байна.

Дөрөв. Дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ:

Тус Цагдаагийн газраас Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллалаа.

Тус Цагдаагийн газрын алба хаагчдаас 2019 онд 43 алба хаагч сахилгын зөрчилд холбогдсоны 26 буюу 60.7 хувийг офицер, 17 буюу 39.2 хувийг ахлагч алба хаагч эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал сахилгын зөрчил 14-өөр буюу 26 хувиар буурсан үзүүлэлтэй байгаа хэдийч гэмт хэрэгт холбогдсон алба хаагчийн тоо өссөн байгаад дүгнэлт хийж 2020 онд алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирох, холбогдохоос урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах.

2019 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар аймгийн төвд 1, Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст 4, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст 2 нийт 7 прокурорын шаардлага ирүүлсэнийг урьд оны мөн үетэй харьцуулахад прокурорын шаардлага 10-аар буюу 58.8 хувиар буурсан үзүүлэлтэй байгаа ч 2020 онд алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр ажил, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах,

Тус Цагдаагийн газар нь 2019 онд улсын хэмжээнд зохион байгуулагдсан "Галт зэвсэг-2019" нэгдсэн арга хэмжээний дүнгээр тэргүүн байр, "Сар шинэ-2019" нэгдсэн арга хэмжээний дүнгээр 2 дугаар байр, "Илрүүлэлт, Оргодол, Шийдвэрлэлт" нэгдсэн арга хэмжээний дүнгээр 2 дугаар байрыг эзэлсэн амжилт, "Шилдэг мөрдөгч"-өөр шалгарсан амжилтуудаа цаашид бататгах,

Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 11 сард 527 холбогдогчтой 2121.6 сая төгрөгийн хохиролтой, 720 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 4 хэргээр буюу 0.5 хувиар буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 54,5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өссөн байна.

Өссөн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон, шинэлэг урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллах шаардлагатайг харуулж байна.

Ялангуяа мал хулгайлах гэмт хэргийг бууруулах, илрүүлэлтийг ахиулах малчдын зөвлөгөөнийг бүсчилсэн хэлбэрээр сумдын Гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран иргэдэд хүрэхүйц ажил, арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

ÄÄÐÄÄ, ÖÄÄÄÄÄÄÈÈÍ
ХУРАНДАА

А.ЭНХБАТ